



2020 оны 02 дугаар сарын 13  
№07 /1109/

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын  
хууль**

**Эрүүгийн хуульд нэмэлт,  
өөрчлөлт оруулах тухай**

**Монгол Улсын  
хууль**

**Эрүүгийн хэрэг хянан  
шийдвэрлэх тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай**

**Монгол Улсын  
хууль**

**Зөрчлийн тухай хуульд  
нэмэлт, өөрчлөлт оруулах  
тухай**

## ГАРЧИГ

### МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

83.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	366
84.	Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай	373
85.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	373
86.	Монгол Улсын шүүхийн тухай хуульд нэмэлт оруулах тухай	382
87.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	383
88.	Усан замын тээврийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	421
89.	Төрийн болон албаны нууцын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	421
90.	Хог хаягдлын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	422
91.	Нийгмийн даатгалын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	422
92.	Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	423
93.	Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	424
94.	Нөхөрлөлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	425
95.	Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	425
96.	Гаалийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	443
97.	Шүүхийн шинжилгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	443
98.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	444
99.	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд нэмэлт оруулах тухай	449
100.	Банкны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай	449



101.	Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		450
102.	Цагдаагийн албаны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		450
103.	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай		451
104.	Зөрчлийн тухай хуульд нэмэлт оруулах тухай		452
<b>МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ</b>			
105.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 03	452
106.	Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай	Дугаар 12	452
107.	Монгол Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай	Дугаар 17	453
108.	Санхүүгийн зохицуулах хорооны зарим гишүүнийг нөхөн томилох тухай	Дугаар 18	455
109.	Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнийг чөлөөлөх тухай	Дугаар 19	455
<b>МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ</b>			
110.	Засгийн газарт чиглэл өгөх тухай /Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай/	Дугаар 10	455
<b>МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ</b>			
2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр		Улаанбаатар хот	
<b>ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ</b>			
<p><b>1 дүгээр зүйл.</b> 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-д доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт, тайлбар нэмсүгэй:</p> <p style="text-align: center;"><b>1/1.10 дугаар зүйлийн 1.5 дахь заалт:</b></p> <p>“1.5.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон, эсхүл зорчих эрхийг хязгаарлах ялын доод хэмжээг зургаан сараас дээш, дээд хэмжээг гурван жил, түүнээс бага хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдсэнээс хойш гурван жил өнгөрсөн.”</p>			



### **2/1.10 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг:**

“5.Татвар төлөхөөс зайлсхийх гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаа гэмт хэрэг үйлдсэн өдрөөс хойш таван жил байна.

6.Хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө гэмт хэрэг үйлдэж энэ хуулийн тусгай ангид хуулийн этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэхээр заасан бол тухайн зүйл, хэсэгт заасан гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацаатай адил байдлаар хөөн хэлэлцэх хугацааг тоолно.”

### **3/6.6 дугаар зүйлийн тайлбар:**

“Тайлбар: -Энэ хуульд заасан “ойр дотны хүн” гэж тухайн хүний эхнэр, нөхөр, хамтран амьдрагч, эцэг, эх, өвөг эцэг, эмэг эх, төрсөн, дагавар, үрчилж авсан хүүхэд, ач, зээ, төрсөн ах, эгч, дүү, хамт амьдарч байгаа бусад төрөл, садангийн хүнийг ойлгоно.”

### **4/8.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Гэмт хэрэг үйлдэх үедээ арван дөрвөн насанд хүрсэн ба арван найман насанд хүрээгүй байсан хүн шүүхийн шийтгэх тогтоол гарах үед арван найман насанд хүрсэн бол энэ хуулийн 8.6 дугаар зүйл хамаарахгүй.”

### **5/12.6 дугаар зүйл:**

#### **“12.6 дугаар зүйл.Биеэ үнэлэхийг зохион байгуулах**

1.Бусдыг биеэ үнэлэхэд зуучилсан, татан оролцуулсан бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Биеэ үнэлэх газар байгуулсан, санхүүжүүлсэн, биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд нь тээврийн хэрэгсэл, орон байр, бусад зүйлээр хангасан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн бол энэ хуульд заасан хүн худалдаалах гэмт хэрэгт хамаарна.”

### **6/13.14 дүгээр зүйл:**

**“13.14 дүгээр зүйл.Худал мэдээлэл тараах**

1.Хүний нэр төр, алдар хүнд, хуулийн этгээдийн ажил хэргийн нэр хүндэд халдсан илт худал мэдээллийг олон нийтэд тараасан бол дөрвөн зуун тавин нэгжээс нэг мянга гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас гурван сар хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

**7/18.5 дугаар зүйлийн тайлбар:**

“Тайлбар: -Энэ зүйлд заасан гэмт хэрэг үйлдэж, улсын хилээр барааг хууль бусаар нэвтрүүлэх гэмт хэргийг илрүүлэх, таслан зогсоход идэвхтэй туслалцаа үзүүлсэн, түүнийг үйлдсэн хүнийг илчилсэн, гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, орлогыг илрүүлсэн хүнийг ялаас чөлөөлнө. Улсын хилээр хууль бусаар нэвтрүүлсэн барааг хяналт шалгалтын үеэр, эсхүл мөрдөн шалгах ажиллагааны үед гаргуулан авсныг сайн дураараа шилжүүлэн өгсөнд тооцохгүй.”

**8/20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол арван хоёр жилээс хорин жил хүртэл хугацаагаар, эсхүл бүх насаар хорих ял шийтгэнэ.”

**9/20.17 дугаар зүйл:****“20.17 дугаар зүйл.Мөрийтэй тоглоом зохион байгуулах**

1.Олон нийтийн газар, эсхүл мэдээллийн технологи ашиглан ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом зохион байгуулсан бол дөрвөн зуун тавин нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог хуулиар хориглосон мөрийтэй тоглоомын газар байгуулсан, эсхүл ажиллуулсан бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**10/21.13 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Гүйцэтгэх ажил явуулах эрхгүй этгээд гүйцэтгэх ажил явуулсан, эсхүл гүйцэтгэх ажлын тусгай техник олж авсан, ашигласан, борлуулсан бол хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **11/22.1 дүгээр зүйлийн тайлбар:**

“Тайлбар: -Энэ хуульд заасан “албан тушаалын байдал” гэдэгт эрх нөлөө хамаарна.

-Энэ хуульд заасан “урвуулан ашиглах” гэж албан үүрэг, албан тушаал, албан тушаалын байдлын эрх мэдлээ албаны эрх ашгийн эсрэг, эсхүл хувийн ашиг сонирхлоо гүйцэлдүүлэх зорилгод ашиглаж хийх ёстой үйлдлийг хийхгүй байх, хийх ёсгүй үйлдэл хийх, эрх мэдлээ хэтрүүлэхийг ойлгоно.”

**2 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 1.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хэрэгт” гэсний дараа “мөрдөн” гэж, 6.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “үйлдсэн” гэсний дараа “, эсхүл шүүхээр ял шийтгүүлэхийн өмнө өөр гэмт хэрэг үйлдсэн нь шүүхийн шийтгэх тогтоол гарсны дараа тогтоогдсон” гэж, 6.13 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “хязгаарлах” гэсний дараа “, нийтэд тустай ажил хийлгэх” гэж, 7.4 дүгээр зүйлийн 9 дэх хэсгийн “нөхцөл” гэсний дараа “, согтуурах, мансуурах донтой” гэж, 11.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн, 11.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “бол” гэсний дараа “хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл” гэж, 11.6 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “хохирол” гэсний дараа “санаатай” гэж, 20.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “бусдад өгсөн” гэсний дараа “, олж авсан” гэж, 24.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хууль бусаар” гэсний дараа “ашиглан үйл ажиллагаа явуулсан,” гэж, 24.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “ховор амьтны чихмэл” гэсний өмнө “нэн” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/2.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Энэ хуульд заасан “ноцтой хохирол, хор уршиг” гэж хохирогчийн амьдралын эх үүсвэр болсон эд хөрөнгийн эрхэд, эсхүл улс орон, хүн амын аюулгүй байдалд ач холбогдол бүхий эрхэд хохирол, хор уршиг учирсныг ойлгоно.”

### **2/12.2 дугаар зүйл:**

**“12.2 дугаар зүйл.Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах**



1.Хохирогчийн хүсэл зоригийнх нь эсрэг хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, эсхүл биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж бэлгийн дур хүслээ ёс бусаар хангасан нь хүчиндэх гэмт хэргийн шинжгүй бол зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Энэ гэмт хэргийг арван дөрвөөс дээш арван найман насанд хүрээгүй хүний эсрэг үйлдсэн бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ гэмт хэргийг бага насны хүүхдийн эсрэг үйлдсэн бол хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

Тайлбар: -Бэлгийн дур хүслээ ёс бусаар хангах гэмт хэргийн хохирогч нь аль ч хүйсийн хүн байж болно.”

### **3/18.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт Монгол Улсын олон улсын гэрээнд заасны дагуу хориглосон бараа, эрдэнэс, эрдсийг Монгол Улсын хилээр, гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн бол дөрвөн зуун тавин нэгжээс таван мянга дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг сараас нэг жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах ял шийтгэнэ.”

### **4/18.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Энэ гэмт хэргийг түүх, соёлын хөдлөх дурсгалт зүйл, музейн үзмэр, эртний амьтны, ургамлын өвөрмөц ховор үнэт олдвор, археологийн, палеонтологийн олдвор, эд өлгийн зүйлийг улсын хилээр хууль бусаар нэвтрүүлж үйлдсэн бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

### **5/18.18 дугаар зүйл:**

#### **“18.18 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн системийн зөвшөөрөлтэй эрхлэх үйл ажиллагааг хууль бусаар эрхлэх**

1.Үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн, эсхүл төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрхийг зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хасаж зургаан сараас хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Үндэсний төлбөрийн системийн оролцогч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэгчийн, эсхүл төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий үйл ажиллагааг эрхлэх зөвшөөрлийг хуурч, эсхүл хуурамч баримт бичиг бүрдүүлэн авсны улмаас бусдын эд хөрөнгө, эдийн болон эдийн бус хөрөнгийн эрхэд ноцтой, эсхүл их хэмжээний хохирол учирсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

3.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гэмт хэргийг үйлдэж бусдад гурван зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, түүнээс дээш хэмжээний хохирол учруулсан бол нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

4.Энэ гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

5.Энэ гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж дөчин мянган нэгжээс хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох ял шийтгэнэ.”

### **6/20.7 дугаар зүйлийн 3.3 дахь заалт:**

“3.3.улсын хилээр нэвтрүүлж үйлдсэн бол таван жилээс арван хоёр жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**4 дүгээр зүйл.**Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “анхан шатны шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болох” гэснийг “яллагдагчаар татах” гэж, 4.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “ойр дотны хүний” гэснийг “эсхүл бусдын” гэж, 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “ял оногдуулна” гэснийг “эрүүгийн хариуцлага хүлээлгэнэ” гэж, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “дөрвөөс” гэснийг “наймаас” гэж, 7.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “тогтоож болно” гэснийг “тогтооно” гэж, 11.3 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “бол нэг жил хүртэл хугацаагаар эрх хасаж” гэснийг “бол хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл” гэж, 12.1 дүгээр зүйлийн 2.10 дахь заалтын “хоёр жилээс найман” гэснийг “таван жилээс арван хоёр” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “таван жилээс арван хоёр” гэснийг “найман жилээс арван таван” гэж, 13.5 дугаар зүйлийн 2.2 дахь заалтын “гурван сараас” гэснийг “зургаан сараас” гэж, 13.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “авсан,” гэснийг “авч, эсхүл” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн, 15.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “бол нэг жил” гэснийг “бол хоёр жил” гэж, 13.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн, 13.11 дүгээр





зүйлийн 1 дэх хэсгийн “Хуулиар хамгаалагдсан хувь хүний” гэснийг “Хувь хүний хуулиар хамгаалагдсан” гэж, 13.11 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “Энэ гэмт хэргийг хувь хүний, ажил хэргийн, худалдаа арилжааны нууцыг ажил үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн эмнэлгийн мэргэжилтэн, сурган хүмүүжүүлэгч, хуульч, хууль сахиулагч, нотариатч, нийгмийн ажилтан, төрийн албан хаагч, сэтгэл зүйч, эвлэрүүлэн зуучлагч, банкны ажилтан, аудитор үйлдсэн” гэснийг “Албан үүргээ гүйцэтгэх явцад олж мэдсэн хувь хүний нууцыг задруулсан” гэж, 16.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Хүүхдэд” гэснийг “Арван найман насанд хүрсэн хүн хүүхдэд” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Хүүхдийг” гэснийг “Арван найман насанд хүрсэн хүн хүүхдийг” гэж, 19.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нууцыг” гэснийг “маш нууцад хамаарах мэдээ, баримт бичиг, эд зүйлийг” гэж, 19.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нууцад” гэснийг “маш нууцад” гэж, 19.12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “маш нууц, онц чухал-маш нууцыг” гэснийг, 19.13 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “онц чухал-маш нууцыг” гэснийг “онц чухал нууцыг” гэж, 20.7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дугаарыг “5” гэж, 20.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “түгээсэн” гэснийг “түгээснээс хүний эрүүл мэндэд хүндэвтэр хохирол учирсан, эсхүл үлэмж хэмжээний хохирол учирсан” гэж, 21.5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хохирол” гэснийг “хохирол, хор уршиг” гэж, 21.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн, 27.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нэг жил хүртэл” гэснийг “хоёр жил хүртэл” гэж, 22.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн, 4 дэх хэсгийн “хоёр жилээс таван жил” гэснийг “таван жилээс найман жил” гэж, 24.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “ноцтой” гэснийг “их хэмжээний” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “Яллагдагч, шүүгдэгч оргон зайлсан бол хөөн хэлэлцэх хугацаа тоолохыг оргон зайлсан өдрөөс зогсоож уг этгээд баригдсан, эсхүл хэргээ өөрөө илчилж ирсэн өдрөөс хөөн хэлэлцэх хугацааг сэргээн тоолно.” гэснийг, 6.7 дугаар зүйлийн гарчгийн “хөнгөрүүлэх,” гэсний дараах “хорих” гэснийг, 21.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “зориуд” гэснийг, “нэг жил хүртэл хугацаагаар эрх хасаж” гэснийг, 21.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “гурван сараас хоёр жил хүртэл хугацаагаар эрх хасаж” гэснийг, 24.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “газар доорх барилга байгууламж барьж” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Эрүүгийн хуулийн 4.1 дүгээр зүйлийн тайлбар, 6.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр мөрдөн байцаалтын шатанд прокурорын тогтоолоор хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгана.

**2 дугаар зүйл.**2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан 2017 оны 07 дугаар сарын 01-ний өдрөөс 2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн хооронд хөөн хэлэлцэх хугацаа дууссан үндэслэлээр шүүхийн шийдвэрээр хэрэгсэхгүй болгосон Эрүүгийн хуулийн Хорин хоёрдугаар бүлэгт заасан гэмт хэргийг сэргээн шалгана.

**3 дугаар зүйл.**2020 оны 01 дүгээр сарын 10-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулиар гэмт хэргийн хөөн хэлэлцэх хугацааг тоолох журам өөрчлөгдсөнтэй холбогдуулан мөрдөн байцаалтын болон шүүхийн шатанд шалгагдаж байгаа гэмт хэрэгт хөөн хэлэлцэх хугацаа тоолохгүй. Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлд Эрүүгийн хуулийн 1.9 дүгээр зүйлд заасан хууль буцаан хэрэглэх зохицуулалт үйлчлэхгүй.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:



**1/3.3 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Сум буюу сум дундын, дүүргийн шүүх, түүнчлэн аймаг, нийслэлийн шүүх тодорхой эрүүгийн хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүн хүрэлцэхгүй болсон бол сум буюу сум дундын, дүүргийн шүүхийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг харьяалах аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн, аймаг, нийслэлийн шүүхийн бүрэлдэхүүнд орох шүүгчийг Улсын дээд шүүхийн Эрүүгийн хэргийн танхимын Тэргүүний шийдвэрээр шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмыг баримтлан томилно.”

**2/4.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Прокурорын даалгаварт гаргасан мөрдөгчийн саналыг дээд шатны прокурор ажлын 3 өдрийн дотор шийдвэрлэнэ.”

**3/6.2 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Энэ зүйлийн 2.14 дэх заалт нь энэ хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1, 2, 3, 4 дэх хэсэгт заасан мөрдөн шалгах ажиллагаа явуулах байгууллага хооронд өгөх даалгаварт хамаарахгүй.”

**4/8.2 дугаар зүйлийн 1.13, 1.14 дэх заалт:**

“1.13.шинжээч томилсон тогтоол, шинжээчийн дүгнэлтийн өөрт хамааралтай хэсэгтэй танилцах;

1.14.өөрийн болон гэр бүлийн гишүүд, эцэг эх, үр хүүхдийнхээ эсрэг мэдүүлэг өгөхгүй байх;”

**5/13.1 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг:**

“11.Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасан хамгаалалтын бусад арга хэмжээг энэ хуульд заасан журмын дагуу хэрэглэнэ.”

**6/14.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх таслан сэргийлэх арга хэмжээний хугацаа дууссан, эсхүл уг арга хэмжээг хүчингүй болгосон, өөрчилсөн шүүхийн шийдвэр гарсан бол прокурор, эсхүл мөрдөгч уг шийдвэрийг яллагдагч болон холбогдох байгууллага, хуулийн этгээдэд даруй хүргүүлнэ.”

**7/14.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасны дагуу барьцааны мөнгийг байршуулах, шилжүүлэх, шийдвэрлэх журмыг Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор, санхүүгийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

**8/29.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Нэг үйлдэлд хэд хэдэн хэрэг бүртгэлтийн хэрэг нээсэн бол хэргийг нэгтгэж хэрэг бүртгэлт явуулна.”

**9/30.7 дугаар зүйлийн 1.6 дахь заалт:**

“1.6.шинжээч томилох.”

**10/30.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Шаардлагатай тохиолдолд мөрдөн шалгах ажиллагаа явуулах албаны дарга энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан хугацааг нэг удаа 14 хүртэл хоногоор сунгаж болно.”

**11/30.8 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Мөрдөгч энэ зүйлийн 1.2-т заасан саналыг прокурорт 72 цагийн дотор хүргүүлнэ.”

**12/30.10 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:**

“4.Мөрдөгчийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг прокурор хянаж, 7 хоногийн дотор шийдвэрлэнэ.

5.Прокурор энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан хугацаанд мөрдөгчийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзах саналыг хянаад үндэслэлгүй гэж үзвэл дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

5.1.гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг дахин шалгуулахаар буцаах;

5.2.хэрэг бүртгэлтийн хэрэг нээх;

5.3.эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах.”

**13/32.9 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Яллагдагчаар татах тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулахдаа хэргийн зүйлчлэлийг хүндрүүлэн өөрчилсөн бол яллагдагчаас дахин мэдүүлэг авна.”

**14/32.10 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэг:**

“7.Яллагдагч яллах дүгнэлтийг гардаж авахаас татгалзвал энэ тухай тэмдэглэл үйлдэж, шаардлагатай бол дуу-дүрсний бичлэгээр баримтжуулж хэргийг шүүхэд шилжүүлнэ.



8.Яллах дүгнэлт гардуулсны дараа хэргийн талаар гаргасан хүсэлт, гомдлыг шүүхэд шилжүүлнэ.”

**15/34.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Өсвөр насны шүүгдэгч, арван найман насанд хүрээгүй хохирогчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах зорилгоор улсын яллагч, хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчийн хүсэлтийг харгалзан шүүх хуралдааныг нээлттэй явуулж болно.”

**16/34.17 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Энэ зүйлд заасан түдгэлзүүлэх нөхцөл арилсан бол шүүх хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааг сэргээнэ.”

**17/38.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Давж заалдах шатны шүүхэд ирсэн хэргийг шүүгчдийн зөвлөгөөнөөс тогтоосон журмын дагуу шүүгчид хуваарилна.”

**18/40.1 дүгээр зүйлийн 9, 10 дахь хэсэг:**

“9.Өмгөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдлыг шүүхэд хүргүүлэхээс өмнө өмгөөлж байгаа хүндээ урьдчилан танилцуулсан байна.

10.Өмгөөлөгч хяналтын журмаар гаргасан гомдлоосоо өмгөөлж байгаа хүнийхээ зөвшөөрөлгүйгээр татгалзаж болохгүй.”

**19/45.9 дүгээр зүйл:**

**“45.9 дүгээр зүйл.Хохирол арилгуулах нэхэмжлэлийг хянан шийдвэрлэх**

1.Хууль зөрчсөн ажиллагааны улмаас учирсан хохирлыг арилгуулах тухай нэхэмжлэлийг Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай хуульд заасан онцгой ажиллагааны журмаар хянан шийдвэрлэнэ.”

**2 дугаар зүйл.**Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтын “13.1/Хүн худалдаалах/,” гэсний дараа “18.2/Валют, үндэсний мөнгөн тэмдэгтийн ханшид нөлөөлөх/,” гэж, 6.2 дугаар зүйлийн 2.11 дэх заалтын “явуулах” гэсний дараа “, даалгаврыг эс зөвшөөрвөл хүлээн авснаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн прокурорын газрын дээд шатны прокурорт саналаа бичгээр нэг удаа гаргах” гэж, 12.4 дүгээр зүйлийн 1.6 дахь заалтын “эд зүйл,” гэсний дараа “мал, амьтан,” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “байгууллага”, “дүнг” гэсний дараа “шүүх,” гэж, 13.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “шүүх” гэсний дараа “, прокурор” гэж, мөн зүйлийн 8 дахь хэсгийн “тухай” гэсний дараа

“прокурор,” гэж, 15.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “дээд шатны прокурорт” гэсний дараа “шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор” гэж, 15.8 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шийдвэрлэнэ.” гэсний дараа “Энэхүү шийдвэр эцсийн байна.” гэж, 17.3 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын, 17.4 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “хуулийн” гэсний дараа “5.3 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 5.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг,” гэж, 17.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “даруй” гэсний дараа “, эсхүл 7 хоногийн дотор” гэж, мөн зүйлийн 5 дахь хэсгийн “хүрээнд” гэсний дараа “шүүгдэгчийн эрх зүйн байдлыг дордуулахгүйгээр” гэж, 21.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “хураан авсан” гэсний дараа “, битүүмжилсэн” гэж, мөн хэсгийн “батална.” гэсний дараа “Прокурор хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэргийг хэрэгсэхгүй болгосон бол хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, эд мөрийн баримт, гэмт үйлдлийн замаар олсон орлого, түүнтэй адилтган үзэх бусад эд зүйлийг хууль ёсны эзэмшигчид нь олгох, эсхүл улсын орлого болгуулахаар шүүхэд санал гаргаж шийдвэрлүүлнэ.” гэж, мөн хэсгийн “шилжүүлэх” гэсний дараа “, хууль ёсны эзэмшигчид нь буцаан олгох, улсын орлого болгох” гэж, 26.7 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “10.1/ Хүнийг алах/,” гэсний дараа “12.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг /Хүчиндэх/,” гэж, 30.7 дугаар зүйлийн 1.3 дахь заалтын “гэрчээс” гэсний өмнө “хохирогч,” гэж, 32.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хамт” гэсний дараа “3 хоногийн дотор” гэж, 33.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “прокурор” гэсний дараа “, яллагдагч, түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгч” гэж, мөн хэсгийн “бичих” гэсний дараа “, гомдол гаргах” гэж, 34.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “нөхцөл” гэсний дараа “, эрүүгийн хариуцлагаас чөлөөлөх, тэнсэх, албадлагын арга хэмжээ хэрэглэх” гэж, 36.9 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “Шүүгдэгч” гэсний дараа “тухайн” гэж, 40.6 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “шүүгч” гэсний дараа “тухайн хэргийг илтгэж,” гэж, 40.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “болгох” гэсний дараа “, өөрчлөх” гэж, 45.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “дотор” гэсний дараа “олон нийтийн мэдээллийн хэрэгслээр” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### **1/2.2 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Шүүх тодорхой хэргийг хянан хэлэлцэх бүрэлдэхүүнгүй болсон бол тухайн хэргийг өөр аймаг дахь сум буюу сум дундын, эсхүл сум буюу сум дундын шүүхээс дүүргийн шүүхэд Улсын дээд шүүхийн эрүүгийн хэргийн танхимын Тэргүүний шийдвэрээр, нэг аймаг дахь өөр сум буюу сум дундын, эсхүл өөр дүүргийн шүүхэд тухайн аймаг, нийслэлийн шүүхийн Ерөнхий шүүгчийн шийдвэрээр шүүхийн харьяалал тогтоон шилжүүлнэ.”

#### **2/6.2 дугаар зүйлийн 2.14 дэх заалт:**

“2.14.өөр нутаг дэвсгэрт мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах, гэмт хэрэг үйлдсэн хүнийг эрэн сурвалжлах



шаардлага гарвал энэ тухай даалгаврыг бичгээр хүргүүлэх ба түүнийг хүлээн авсан мөрдөн шалгах байгууллага даалгаврыг заасан хугацаанд биелүүлж, хариуг цугларсан нотлох баримтын хамтаар ирүүлэх;”

### **3/8.2 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Хохирогч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

### **4/9.6 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Гэрч эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд саад учруулсан, эсхүл худал мэдүүлэг өгсөн бол түүнд Зөрчлийн тухай хууль, эсхүл Эрүүгийн хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

### **5/10.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Энэ хуулийн 13.5 дугаар зүйлд заасны дагуу хамтран ажиллах этгээдээр тогтоосон шийдвэр гаргасан шүүгч уг хүний үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэхэд оролцож болохгүй.”

### **6/24.5 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Мөрдөгч төрийн нууц, хувь хүний эрүүл мэнд, захидал харилцааны нууцтай холбоотой эрүүгийн хэрэгт ач холбогдол бүхий мэдээлэл, баримт бичгийг холбогдох байгууллага, албан тушаалтан, хүнээс прокурорын зөвшөөрлөөр гаргуулан авна.”

### **7/26.1 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь заалт:**

“1.1.үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хянах;

1.2.үл хөдлөх болон эдийн бус хөрөнгө, санхүүгийн болон өрийн хэрэгсэл, улсын бүртгэл, зохиогчийн эрх, патент, гэрчилгээ, лиценз, тусгай зөвшөөрөл, тээврийн хэрэгслийн бүртгэлтэй холбоотой шилжилт хөдөлгөөн, банк, бусад санхүүгийн байгууллагад байгаа мөнгөн хөрөнгийн гүйлгээний шилжилт хөдөлгөөнийг хязгаарлахыг зохих байгууллагад даалгах.”

### **8/30.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан тухай гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэх ба энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан

прокурорын шийдвэрийг гомдол, мэдээлэл гаргагч эс зөвшөөрвөл шийдвэр хүлээн авсан өдрөөс хойш 7 хоногийн дотор дээд шатны прокурорт гомдол гаргаж болно.”

### **9/31.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Гэмт хэрэг үйлдсэнээс хойш Эрүүгийн хуулийн 1.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан тухайн хэргийг хөөн хэлэлцэх хугацааг хоёр дахин нэмэгдүүлсэнтэй тэнцэх хугацаа өнгөрсөн бол мөрдөн байцаалтын хугацааг сунгаж болохгүй. Энэ хуулийн 31.14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу мөрдөн байцаалтыг түдгэлзүүлсэн, эсхүл хэргийг прокурорт шилжүүлсэн бол мөрдөн байцаалтын хугацааг зогсооно. Түдгэлзүүлсэн хэргийг сэргээсэн, эсхүл хэрэгт нэмэлт ажиллагаа хийлгэхээр прокуророос мөрдөгчид хэргийг буцааснаас эхлэн мөрдөн байцаалтын хугацааг үргэлжлүүлэн тоолно.”

### **10/37.5 дугаар зүйл:**

#### **“37.5 дугаар зүйл.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулах**

1.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүн, жирэмсэн эмэгтэй, гурав хүртэлх насны хүүхэдтэй эх, ганц бие эцэгт хорих ял оногдуулсан шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг 2 жил хүртэл хугацаагаар хойшлуулж болно. Энэ хугацаанд ялтанд шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага хяналт тавина.

2.Шүүх анх удаа хөнгөн гэмт хэрэг үйлдсэн өсвөр насны хүнд хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулахдаа Эрүүгийн хуулийн 7.3 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт заасан үүрэг хүлээлгэж, хязгаарлалт тогтоож болно.

3.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан өсвөр насны хүн шүүхээс тогтоосон хугацаанд хүлээлгэсэн үүргийг биелүүлээгүй, эсхүл тогтоосон хязгаарлалтыг зөрчсөн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

4.Ялтан хүүхдээ асарч хүмүүжүүлэхээс зайлсхийсэн бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх хорих ял оногдуулсан шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан шийдвэрийг хүчингүй болгож, хорих ялыг биечлэн эдлүүлэх тухай шийдвэр гаргана.

5.Шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд уг этгээд санаатай гэмт хэрэг үйлдвэл шүүх Эрүүгийн хуулийн 6.9 дүгээр зүйлд заасныг баримтлан ял оногдуулна.





6.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан этгээд шүүхийн шийтгэх тогтоол биелүүлэхийг хойшлуулсан хугацаанд шүүхээс хүлээлгэсэн үүрэг, тогтоосон хязгаарлалтыг зөрчөөгүй бол прокурорын дүгнэлтийг үндэслэн шүүх ялаас чөлөөлнө.”

#### **11/40.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг:**

“1.Давж заалдах шатны шүүхийн шийдвэрт дараах үндэслэлээр оролцогч хяналтын журмаар гомдол, прокурор, дээд шатны прокурор эсэргүүцэл гаргаж болно:

1.1.шүүх Эрүүгийн хуулийг буруу хэрэглэсэн;

1.2.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн нь шүүхийн шийдвэрт нөлөөлсөн, эсхүл нөлөөлж болохуйц нөхцөл байдал тогтоогдсон.”

#### **12/40.2 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасан шүүгчийн шийдвэрийг гомдол, эсэргүүцэл гаргагч эс зөвшөөрвөл 10 хоногийн дотор Улсын дээд шүүхэд гомдол гаргах эрхтэй бөгөөд гомдлыг 3 шүүгчийн бүрэлдэхүүнтэй 14 хоногийн дотор хэлэлцэж шийдвэрлэнэ. Энэхүү шийдвэр эцсийн байна.”

#### **13/45.2 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг:**

“1.Хүнийг хууль бусаар ял шийтгэсэн, баривчилсан, цагдан хорьсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн, эмнэлгийн байгууллагад байлгасан, албадан эмчлэх арга хэмжээ хэрэглэсэн, эрүүдэн шүүсний улмаас учирсан хохирлыг мөрдөгч, прокурор, шүүгчийн гэм бурууг үл харгалзан төр хариуцан арилгана.

2.Хохирол нөхөн төлүүлэх эрх дараах тохиолдолд үүснэ:

2.1.хууль бусаар баривчлагдсан, цагдан хоригдсон, тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түр түдгэлзүүлсэн нь тогтоогдсон;

2.2.тухайн хүнийг цагаатгасан шүүхийн шийдвэр гарсан;

2.3.тухайн хэрэг нь гэмт хэргийн шинжгүй, эсхүл тухайн хүн гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдоогүйгээс хэргийг хэрэгсэхгүй болгосон;

2.4.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай шүүхийн хууль бус шийдвэрийг хүчингүй болгосон;

2.5.яллагдагчийг эрүүдэн шүүсэн болох нь нотлогдсон.”

**4 дүгээр зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн

6.1 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтын “зүйлд” гэснийг “зүйл, 20.7 дугаар зүйлийн 3.3-т” гэж, 8.2 дугаар зүйлийн 1.13 дахь заалтын дугаарыг “1.15” гэж, 12.1 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “ирүүлж болно” гэснийг “ирүүлнэ” гэж, 12.4 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “яллагдагчийг” гэснийг “яллагдагч, шүүгдэгчийг” гэж, 14.9 дүгээр зүйлийн 1.3 дахь заалтын “дахин үйлдэх” гэснийг “үйлдэж болзошгүй” гэж, 15.4 дүгээр зүйлийн гарчгийн “хангах” гэснийг “шийдвэрлэх” гэж, 15.7 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Улсын ерөнхий” гэснийг “дээд шатны” гэж, 17.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “баримт, нөхөн төлөхөө илэрхийлж хохирогчтой эвлэрсэн тухай баталгааг” гэснийг “баримтыг” гэж, 17.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “6.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулах” гэснийг “5.5 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.7 дугаар зүйлд заасныг үндэслэн ял оногдуулах, ялаас чөлөөлөх, ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх” гэж, 17.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хүлээлгэх эрүүгийн хариуцлагын төрөл, хэмжээний талаархи саналыг яллагдагчид танилцуулж,” гэснийг “оногдуулах ялын төрөл, хэмжээ, эсхүл ялаас чөлөөлөх, эсхүл ял оногдуулахгүй тэнсэж албадлагын арга хэмжээ хэрэглэх тухай саналыг яллагдагч, түүний өмгөөлөгчид танилцуулж, яллагдагч” гэж, 17.4 дүгээр зүйлийн 4.3 дахь заалтын “ялыг” гэснийг “ял, албадлагын арга хэмжээг” гэж, мөн зүйлийн 4.5 дахь заалтын “илэрхийлж хохирогчтой эвлэрсэн” гэснийг “илэрхийлсэн” гэж, 19.3 дугаар зүйлийн 4.4 дэх заалтын “4.2, 4.3-т заасан шийдвэрийн аль нэгийг” гэснийг “4.2-т заасан шийдвэрийг” гэж, 30.3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “гомдлыг” гэснийг “гомдол, мэдээллийг” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “гомдол гомдол гаргагч” гэснийг “гомдол, мэдээлэлд гомдол гаргагч, эсхүл мэдээлэл өгсөн хүн” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “гомдол” гэснийг “гомдол, мэдээлэл” гэж, 30.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эрүүгийн хэрэг үүсгэх” гэснийг “хэрэг бүртгэлтийн хэрэг нээх” гэж, 30.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Мөрдөгч хэрэг бүртгэлтийг дуусгаж, дараахь саналыг прокурорт хүргүүлнэ” гэснийг “Мөрдөгч хэрэг бүртгэлтийг дуусгаж, дараахь саналын аль нэгийг гаргаж хэргийн хамт ажлын 3 өдрийн дотор прокурорт хүргүүлнэ” гэж, 30.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “авч,” гэснийг “авснаас хойш ажлын 3 өдрийн дотор” гэж, 31.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “б” гэснийг “12” гэж, 31.8 дугаар зүйлийн гарчгийн “Баривчлагдсан сэжигтний” гэснийг “Сэжигтний” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “Баривчлагдсан сэжигтэн” гэснийг “Сэжигтэн” гэж, 37.11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих, торгох,” гэснийг “Торгох,” гэж, 39.4 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хэргийн болон” гэснийг “хэргийг илтгэж,” гэж, 40.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “30” гэснийг “14” гэж, Дөчин тавдугаар бүлгийн гарчгийн “МӨРДӨГЧ, ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТНЫ” гэснийг “МӨРДӨГЧИЙН” гэж, 45.6 дугаар зүйлийн гарчгийн “Хэргийг хэрэгсэхгүй болгосон” гэснийг “Хууль зөрчсөн ажиллагааны” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “бусад” гэснийг “тодорхой үйл ажиллагаа явуулах, албан үүргээ биелүүлэхийг түдгэлзүүлэх” гэж тус тус өөрчилсүгэй.



**5 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 24.5 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “прокурорын зөвшөөрлөөр” гэснийг, 30.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “энэ хуулийн 22.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт зааснаас гадна” гэснийг, 34.16 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “хэргийн бодит байдлыг тогтооход нөлөөлөхгүй бол” гэснийг, 37.11 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн, 37.12 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “хорих ялыг зорчих эрхийг хязгаарлах ялаар солих,” гэснийг, 45.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “эрх бүхийн албан тушаалтан,” гэснийг, 45.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон” гэснийг, 45.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “эсхүл эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах тогтоолыг хүчингүй болгосон болон” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 14.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 17.4 дүгээр зүйлийн 4.4 дэх заалт, 17.5 дугаар зүйл, 34.19 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 39.9 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 40.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 40.8 дугаар зүйлийн 1.7 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.** Энэ хуулийг 2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-д нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

## МОНГОЛ УЛСЫН ШҮҮХИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Монгол Улсын шүүхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.1 дэх заалтын “бөгөөд” гэсний өмнө “Үндсэн хуулиас бусад хуулийг зөв хэрэглэх талаар албан ёсны тайлбар гаргах” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, тайлбар нэмсүгэй:

#### **1/3.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Арван дөрвөөс арван зургаа хүртэл насны хүн энэ хуулийн тусгай ангийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг, 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 8.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 14.7 дугаар зүйлийн 5 дахь хэсэгт заасан зөрчил үйлдсэн бол түүнд шийтгэл хүлээлгэнэ.”

#### **2/3.5 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Хэд хэдэн зөрчилд оногдуулсан баривчлах шийтгэлийн нийт хугацаа гурван сараас хэтрэхгүй байна.”

#### **3/5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн тайлбар:**

“Тайлбар: Энэ хуульд заасан “орон байр” гэж хүн байнга, түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно.”

#### **4/5.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Пиротехникийн хэрэгслийг үйлдвэрлэх, импортлох, ашиглах дүрмийг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **5/5.19 дүгээр зүйл:**

#### **“5.19 дүгээр зүйл.Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах**

1.Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **6/6.5 дугаар зүйлийн 15, 16 дахь хэсэг:**

“15.Аймаг, нийслэлийн Засаг дарга, эсхүл чөлөөт бүсийн захирагчийн харьяалах нутаг дэвсгэртээ согтууруулах ундаа худалдах,



түүгээр үйлчилгээ эрхлэх тусгай зөвшөөрөлтэй худалдаа, үйлчилгээний газрын үйл ажиллагаа явуулах цагийн хязгаарыг тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16.Хорин нэгэн нас хүрээгүй хүнийг уруу татаж согтууруулах ундаа уулгасан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **7/6.6 дугаар зүйлийн 12 дахь хэсэг:**

“12.Заавал хийх дархлаажуулах бэлдмэл, эсхүл үнэ төлбөргүй олгох зориулалттай буцалтгүй тусламжийн эм, эмнэлгийн хэрэгслийг худалдсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **8/6.15 дугаар зүйлийн 9, 10 дахь хэсэг:**

“9.Хүнсний чиглэлийн үйл ажиллагаа эрхлэгч нь хүнсний бүтээгдэхүүний чанар, аюулгүй байдлыг хангаагүй түүхий эд, бүтээгдэхүүнээр үйлдвэрлэл явуулсан, хадгалсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Буруу шошголсон, шошгын мэдээлэл шаардлага хангаагүй хүнсний түүхий эд бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн, худалдсан, импортолсон бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **9/6.16 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Баталгаажуулалтын байгууллага нь:

4.1.хуульд заасан журмыг зөрчиж органик хүнсийг баталгаажуулсан;

4.2.органик үйлдвэрлэл эрхлэгчийн мэдээллийг хуульд заасан хугацаанд холбогдох төрийн байгууллагад мэдэгдээгүй бол итгэмжлэлийг хүчингүй болгож хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **10/6.23 дугаар зүйл:**

**“6.23 дугаар зүйл.Олон улсын хөл хориот өвчний талаар мэдүүлэхээс татгалзах**

1.Олон улсын хөл хориот өвчин гарсан улс орноос ирсэн хүн эрүүл мэндийн тодорхойлолтыг мэдүүлэхээс татгалзсан, эсхүл үнэн зөв мэдүүлээгүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**11/6.24 дүгээр зүйл:**

**“6.24 дүгээр зүйл.Агаарын бохирдлоос урьдчилан сэргийлэх**

1.Стандартад нийцсэн утааны шүүлтүүргүй дизель хөдөлгүүртэй автобус, ачааны машиныг замын хөдөлгөөнд оролцуулсан бол зөрчлийг арилгуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Агаарын бохирдлоос хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилгоор тодорхой нутаг дэвсгэрт хориглолт тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн, хориглосон бүсэд түүхий нүүрс зөвшөөрөлгүй тээвэрлэсэн, эсхүл нэвтрүүлсэн бол зөрчилтэй эд зүйлийг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**12/6.25 дугаар зүйл:**

**“6.25 дугаар зүйл.Баяжуулсан хүнсний тухай хууль зөрчих**

1.Баяжуулсан хүнс үйлдвэрлэгч нь:

1.1.бүтээгдэхүүн үйлдвэрлэхдээ үндэсний стандартыг мөрдөөгүй, дотоод хяналтын тогтолцоог бүрдүүлээгүй, эсхүл үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн болон баяжуулагч бэлдмэлээ итгэмжлэгдсэн лабораториор баталгаажуулаагүй;

1.2.албан журмаар баяжуулах хүнсийг баяжуулалгүй үйлдвэрлэсэн;

1.3.баяжуулсан хүнс үйлдвэрлэх, хадгалах, тээвэрлэх журмыг зөрчсөн бол хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Баяжуулсан хүнсний нэр, төрөл, үйлдвэрлэл, борлуулалтын мэдээллийг мэдээллийн санд бүртгүүлэх үүргээ биелүүлээгүй, эсхүл баяжуулсан хүнс болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журмыг зөрчсөн бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.



### 3.Баяжуулагч бэлдмэл импортлогч нь:

3.1.баяжуулагч бэлдмэлийн чанар, аюулгүй байдлыг алдагдуулахгүй байх тээвэрлэлт, хадгалалтын горимыг мөрдөөгүй;

3.2.албан журмаар баяжуулах хүнсний жагсаалтад зааснаас өөр найрлага бүхий баяжуулагч бэлдмэл импортолсон;

3.3.гарал үүсэл, чанар, аюулгүй байдлын баталгаажуулалтын гэрчилгээгүй баяжуулагч бэлдмэл импортолсон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Баяжуулсан хүнс импортлогч нь албан журмаар баяжуулах хүнсний стандартын шаардлага хангаагүй, эсхүл тэмдэг, тэмдэглэгээгүй баяжуулсан хүнс импортолсон бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **13/6.26 дугаар зүйл:**

##### **“6.26 дугаар зүйл.Бэлгийн дарамт учруулах**

1.Бусдад ажил, албан тушаал, нэр төр, алдар хүнд, эд хөрөнгө, сэтгэл санааны үр дагавар үүсгэж бэлгийн харьцааны шинжтэй үйлдэл хийх сэдлээ үг хэлээр, биеэр, өөр хэлбэрээр илэрхийлсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

2.Ажил олгогч хөдөлмөрийн дотоод журамд ажлын байран дахь бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэх, гарсан гомдлыг барагдуулах хэм хэмжээг тусгах үүргээ биелүүлээгүй бол хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **14/7.6 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад амьтан, тэдгээрийн гаралтай түүхий эдийг гарал үүслийн тодорхойлолтгүйгээр худалдсан, худалдан авсан бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **15/7.8 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Ургамал, түүнээс гаралтай түүхий эдийг тээвэрлэх, борлуулахдаа тухайн сум, дүүргийн Засаг даргын Тамгын газраас бүтээгдэхүүний гарал

үүслийн гэрчилгээ аваагүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**16/8.9 дүгээр зүйл:**

**“8.9 дүгээр зүйл.Алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, гээгдэл эд хөрөнгө завших**

1.Төлбөр тооцооны алдаатай гүйлгээ, андуурагдсан илгээмж, эд хөрөнгө, гээгдэл эд хөрөнгийг завшсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**17/9.11 дүгээр зүйл:**

**“9.11 дүгээр зүйл.Мэргэжлийн боловсрол, сургалтын тухай хууль зөрчих**

1.Хуульд заасан тусгай зөвшөөрөлгүйгээр үйл ажиллагаа явуулсан, эсхүл улсын бүртгэлд бүртгүүлэлгүй боловсролын сургалтын үйл ажиллагаа эрхэлсэн бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Мэргэжлийн боловсрол, сургалтын стандартыг мөрдөөгүй, эсхүл эрүүл аюулгүй орчин нөхцөлийг бүрдүүлэлгүй сургалт явуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**18/10.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Үйлдвэрлэгч, худалдагч, гүйцэтгэгчээс хэрэглэгчийг төөөргдүүлэх замаар бараа, ажил, үйлчилгээний хиймэл хомсдол үүсгэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**19/10.9 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Нөхөрлөл оршин байгаа газраа өөрчилсөн тухайгаа харьяалах бүртгэх байгууллагад хуульд заасан хугацаанд бичгээр мэдэгдээгүй бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**20/10.16 дугаар зүйлийн 10, 11 дэх хэсэг:**





“10.Ажил олгогч нь ажилтны ажил, мэргэжил, мэргэшил, албан тушаал, цалин хөлсний тухай тодорхойлолтыг гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Ажил хаялтад оролцох, түүнийг үргэлжлүүлэхийг, эсхүл хуульд зааснаас бусад тохиолдолд ажил хаялтыг зогсоох, түүнд оролцохоос татгалзахыг ажилтанд тулган шаардсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **21/11.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч:

6.1.төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан, эсхүл гүйлгээг саатуулсан;

6.2.тайлан, тэнцэл, мэдээ баримтыг Санхүүгийн зохицуулах хороонд зохих журмын дагуу гаргаж өгөөгүй, эсхүл энэ хуульд заасны дагуу нийтэд мэдээлэх санхүүгийн тайланг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр нийтэд мэдээлээгүй, эсхүл нийтлүүлсэн тайлан мэдээлэлд хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулагдсан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **22/11.10 дугаар зүйлийн 12-15 дахь хэсэг:**

“12.Хүн, хуулийн этгээд:

12.1.үнэт цаас гаргах тухай шийдвэрийг эрх бүхий байгууллагад бүртгүүлснээс хойш түүний зөвшөөрснөөс бусад тохиолдолд тухайн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд арилжих хүртэл хугацаанд өөрчилсөн;

12.2.урьд нь нийтэд санал болгон гаргасан тухайн төрлийн үнэт цаасыг нэмж гаргахдаа хаалттай хүрээнд худалдахаар шийдвэрлэсэн тухайгаа эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй;

12.3.урьд нь нийтэд санал болгон үнэт цаас гаргасан хуулийн этгээд өөр төрлийн үнэт цаасыг хаалттай хүрээнд худалдахаар гаргаж байгаа бол уг үнэт цаасыг эрх бүхий байгууллагад бүртгүүлээгүй;

12.4.Засгийн газраас гаргасан үнэт цааснаас бусад нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлээгүй, эсхүл эрх бүхий байгууллага уг бүртгэлд бүртгэхээс татгалзсан үнэт цаасыг нийтэд танилцуулсан, эсхүл зар сурталчилгаа явуулсан;



12.5.үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаасыг зээлээр худалдсан, эсхүл хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол үнэ төлбөргүйгээр эзэмшүүлсэн;

12.6.үнэт цаас гаргагч нь үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд худалдаж дууссанаас хойш ажлын 3 өдрийн дотор тухайн үнэт цаасыг үнэт цаасны анхдагч зах зээлд арилжсан тухай тайланг тогтоосон журмын дагуу эрх бүхий байгууллагад ирүүлэх үүргээ биелүүлээгүй;

12.7.Монгол Улсад бүртгэгдсэн хуулийн этгээд гадаад улсын хөрөнгийн биржид бүртгүүлэх тохиолдолд эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

12.8.шүүхийн шийдвэрийн дагуу үнэт цаас гаргагчийн дүрэмд оруулсан нэмэлт, өөрчлөлттэй зөрчилдсөн нэмэлт, өөрчлөлтийг уг дүрэмд оруулсан;

12.9.эрх бүхий байгууллагаас тогтоосон журам зөрчиж санал гаргасан, эсхүл санал гаргалгүй компанийн хувьцааг худалдан авахад чиглэсэн үйл ажиллагаа явуулсан;

12.10.хуульд заасан зохицуулалттай үйл ажиллагааг эрхлэх зохицуулалттай этгээдийн хувьцаа эзэмшигч нь эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хувьцаагаа худалдах, арилжих, барьцаалах болон бусад хэлбэрээр шилжүүлсэн;

Тайлбар: Энэ заалт нь хувьцаат компанийн хэлбэртэй зохицуулалттай этгээдийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид хамаарна.

12.11.хөрөнгө оруулалтын менежментийн компани нь үйлчилгээний зардлын төлбөр, гүйцэтгэлийн урамшууллаас бусад төлбөр, хураамжийг сангийн хөрөнгөөс гаргасан;

12.12.үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн мэдээлэл, баримтыг хууль тогтоомжоор тогтоосон хугацаанд бүрэн бүтэн хадгалах, эсхүл зохих журмын дагуу мэдээлэх, тайлагнах үүргээ биелүүлээгүй;

12.13.үнэт цаас өмчлөгч /итгэмжлэгдсэн өмчлөгч/, кастодианы болон брокерын үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь үнэт цаасны тухайлсан бүртгэлд гаргаж өгөх шаардлагатай мэдээллийг үнэн зөв, шуурхай гаргаж өгөх үүргээ биелүүлээгүй;

12.14.нэг үнэт цаасыг үнэт цаасны тухайлсан бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа зөвхөн нэг хуулийн этгээдэд бүртгүүлсэн, эсхүл өөр хуулийн этгээдэд давхар бүртгүүлсэн;



12.15.үнэт цаасны арилжааны төлбөрийн гүйлгээг төлбөр бүрэн хийгдсэн тохиолдолд үнэт цаасны өмчлөх эрхийг шилжүүлэх зарчмыг баримтлан гүйцэтгэх үүргээ биелүүлээгүй;

12.16.үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь үнэт цаасны өмчлөх эрх шилжсэн тухай үнэт цаас гаргагчид хүсэлтээр болон үнэт цаасны бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

12.17.үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд бусдын өмнө хүлээсэн үүргийг түүний харилцагчийн дансан дахь үнэт цаас, түүнтэй холбоотой мөнгөн хөрөнгөөр гүйцэтгэсэн;

12.18.хөрөнгийн бирж хуулиар үүрэг болгосон журмыг баталж, нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

12.19.хөрөнгийн бирж үнэт цаасны арилжааны талаарх хуульд заасан мэдээллийг нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

12.20.хөрөнгийн биржийн эрх бүхий албан тушаалтан үнэт цаасны арилжаанд оролцогч зохицуулалттай хуулийн этгээдэд аливаа албан тушаал эрхэлсэн;

12.21.хуулиар зөвшөөрснөөс бусад зохицуулалттай үйл ажиллагааг хавсран эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.Үнэт цаасны зэх зээлийн оролцогч, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч, аудитор:

13.1.кастодианы үйл ажиллагаа эрхлэх байгууллага хувьцаат компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа, эсхүл холбогдох этгээдтэй хамтран худалдан авснаар тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцаа нь хяналтын багц болон түүнээс дээш хэмжээнд хүрсэн бол хяналтын багц эзэмшигч болсон өдрөөс хойш ажлын 60 өдрийн дотор бусад хувьцаа эзэмшигчийн эзэмшиж байгаа хувьцааг уг хувьцааны сүүлийн зургаан сарын зах зээлийн үнийн жигнэсэн дунджаас доогуур үнээр худалдан авахаар санал гаргах үүрэг үүссэн тухай мэдээллийг компанийн хувьцааны хяналтын багцыг худалдан авснаас хойш ажлын 5 өдрийн дотор эрх бүхий байгууллага, хөрөнгийн биржид мэдэгдэх, нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

13.2.компанийн хувьцааны хяналтын багцыг дангаараа болон холбогдох этгээдтэй хамтран эзэмшиж байгаа этгээд нь уг хувьцааны



хяналтын багцын хэмжээ нь 5 хувиар нэмэгдсэн, буурсан тохиолдол бүрд ажлын 5 өдрийн дотор эрх бүхий байгууллага, хөрөнгийн биржид мэдэгдэх, нийтэд өөрийн цахим хуудсаар дамжуулан мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

13.3.санал гаргагч нь компанийн хувьцааг худалдан авах саналаа эрх бүхий байгууллага болон нийтэд нэгэн зэрэг мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

13.4.зохицуулалттай этгээд тусгай зөвшөөрөл бүхий үйл ажиллагаатай холбоотой хийсэн хэлцэл, өөрийн болон харилцагчийн хөрөнгийн хөдөлгөөн, өөрчлөлтийг бүрэн тусгасан анхан шатны болон нягтлан бодох бүртгэл хөтлөх, баланс орлого, үр дүнгийн тайланг цаг тухайд нь үнэн зөв гаргах үүргээ биелүүлээгүй;

13.5.зохицуулалттай этгээд энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан баримт бичиг, бүртгэлийг өөрийн байгууллагад 5-аас доошгүй жил хадгалан архивт шилжүүлэх үүргээ биелүүлээгүй;

13.6.зохицуулалттай этгээд нь тусгай зөвшөөрөл авснаас хойш нэг сарын дотор эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн аудитын байгууллагыг сонгон гэрээ байгуулах, эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

13.7.хуулиар хориглосон этгээдийг аудиторроор томилсон;

13.8.зохицуулалттай этгээд нь аудитын байгууллагатай байгуулсан гэрээг цуцалснаас, эсхүл дуусгавар болсноос хойш 7 хоногийн дотор энэ тухайгаа эрх бүхий байгууллагад бичгээр мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

13.9.хуульд заасны дагуу аудитын шалгалт хийх явцад зохицуулалттай этгээдийн санхүүгийн байдалд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхүйц болон санхүүгийн бусад зохицуулалтыг зөрчсөн нөхцөл байдал илэрвэл аудитор энэ тухай эрх бүхий байгууллагад, эсхүл зохицуулалттай этгээдэд даруй бичгээр мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

13.10.хөрөнгийн бирж нь өөрийн бүртгэлд байгаа үнэт цаас, үнэт цаас гаргагчийн талаарх хуульд заасан мэдээллийг цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

13.11.тусгай зөвшөөрөлтэйгөөр зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх этгээд нь хуульд заасан мэдээллийг хуульд заасан этгээдэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

13.12.Санхүүгийн зохицуулах хороо шаардсан тохиолдолд хөрөнгө оруулагч нь өөрийн, эсхүл түүний холбогдох этгээдийн өмчлөл дэх үнэт цаасны талаарх мэдээллийг гаргаж өгөөгүй;



13.13.энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан эрх хэмжээний хүрээнд олж авсан баримт, материал, мэдээллийг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр аливаа этгээдэд мэдээлсэн, шилжүүлсэн;

13.14.зохицуулалттай этгээд нь харилцагчийн хөрөнгийг хамгаалахад шаардлагатай холбогдох бүх данс, баримт, материалын эхийг эрх хүлээн авагчид шилжүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.Үнэт цаасны зэх зээлийн оролцогч, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч, аудитор нь тухайн санхүүгийн тайлангийн жил дуусах тухай бүр нягтлан бодох болон бусад бүртгэлдээ аудитын шалгалт хийлгэж, санхүүгийн тайлангийн аудитаар баталгаажуулсан хувийг аудитын дүгнэлтийн хамт Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжид заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хүргүүлэх үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15.Үнэт цаасны зэх зээлийн оролцогч, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч, аудитор:

15.1.үнэт цаасны анхдагч зах зээлд үнэт цаас гаргагч нь хуульд заасан мэдээллийг үнэ төлбөргүйгээр сонирхсон этгээдэд өгөх үүргээ биелүүлээгүй;

15.2.үнэт цаасны хоёрдогч зах зээлд үнэт цаасаа арилжиж байгаа үнэт цаас гаргагч нь хуульд заасан нөхцөл байдал үүссэнээс хойш ажлын 1 өдөрт багтаан энэ талаар эрх бүхий байгууллага, хөрөнгийн бирж, эсхүл өөрийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

15.3.хөрөнгө оруулагч нь өөрийн өмчлөл дэх үнэт цаасыг бүртгүүлэх, номиналь эзэмшигчид шилжүүлэхдээ үнэт цаастай холбоотой, шаардлагатай бүх мэдээллийг үнэт цаасны бүртгэл хөтлөгч, эсхүл номиналь эзэмшигчид мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

15.4.өөрийгөө зохицуулах байгууллага нь түүний гишүүдийн үйл ажиллагаатай холбоотой асуудлаар эрх бүхий байгууллагаас ирүүлсэн аливаа мэдээллийг гишүүн бүрд шуурхай хүргэх үүргээ биелүүлээгүй;

15.5.өөрийгөө зохицуулах байгууллага нь эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

15.6.өөрийгөө зохицуулах байгууллага нь түүний гишүүдээс хууль тогтоомж, байгууллагын дүрэм, журам зөрчсөн талаар болон уг зөрчилтэй холбогдуулан авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тухай эрх бүхий байгууллагад даруй мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

15.7.өөрийгөө зохицуулах байгууллага санхүүгийн, эсхүл үйл ажиллагааны тайлангаа тогтоосон хугацаанд эрх бүхий байгууллагад ирүүлэх, нийтэд мэдээлэх үүргээ биелүүлээгүй;

15.8.хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас өөрийгөө зохицуулах байгууллага, түүний эрх бүхий албан тушаалтан, мэргэжилтэнд арга хэмжээ авсан өдрөөс хойш уг асуудлыг удирдах зөвлөл, эсхүл бүх гишүүдийн хурлаар 60 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж, эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

### **23/11.13 дугаар зүйлийн 13-17 дахь хэсэг:**

“13.Хуульд заасныг зөрчиж даатгагчийн энгийн хувьцааны 10, түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл бусад этгээдтэй хамтран эзэмшиж байгаа этгээд өөрийн өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг эрх бүхий байгууллагын бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр бусдад шилжүүлсэн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.Хуульд заасныг зөрчиж аливаа этгээд эрх бүхий байгууллагаас бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр даатгагчийн энгийн хувьцааны 10, түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл бусад этгээдтэй хамтран шууд, шууд бусаар эзэмшсэн, эсхүл өмчилсөн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

### **15.Даатгагч:**

15.1.хуулиар тогтоосон даатгалын компанийн дүрмийн сангийн доод хэмжээг бүрдүүлээгүй;

15.2.хуульд заасан даатгалын нөөц санг бүрдүүлээгүй;

15.3.хуулиар тогтоосон ногдол ашиг хуваарилах нөхцөлийг зөрчиж ногдол ашиг хуваарилсан, эсхүл хуваарилахаар зарласан;

15.4.хуульд заасан төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлтийг дагаж мөрдөөгүй;



15.5.даатгагч нь нягтлан бодох бүртгэлээ аккруэл сууриар хөтлөөгүй;

15.6.нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангаа зохих ёсоор хөтлөөгүй;

15.7.компанийн нэгдлийн гишүүнчлэлтэй нь холбогдуулан эрх бүхий байгууллагаас шаардсан тухайн нэгдлийн гишүүн аль ч этгээдийн санхүүгийн болон компанийн нэгдлийн нэгдсэн тайланг ирүүлээгүй;

15.8.эрх бүхий байгууллагаас даатгагчийн санхүүгийн байдлын талаарх шаардлагатай гэж үзсэн асуудлыг актуарчаар шалгуулах, эсхүл актуарын тайлан гаргаж өгөхийг шаардсаныг биелүүлээгүй;

15.9.даатгалын эрсдэлийг хариуцах үүргээ давхар даатгуулах төлөвлөгөөг даатгалын багц дүрэмд заасны дагуу эрх бүхий байгууллагаар батлуулаагүй;

15.10.бизнес төлөвлөгөөг батлуулах, үйл ажиллагаагаа эрх бүхий байгууллагаас хамгийн сүүлд баталсан бизнес төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх, дагаж мөрдөх үүргээ биелүүлээгүй;

15.11.давхар даатгалын төлөвлөгөөний нарийвчилсан тайланг тогтоосон хугацаанд гаргаж эрх бүхий байгууллагад хүргүүлэх, эсхүл тайланд давхар даатгалын гэрээний хуулбарыг хавсаргах үүргээ биелүүлээгүй;

15.12.урт хугацааны даатгагчийн сан байгуулах, түүнийг зарцуулах журам зөрчсөн;

15.13.ерөнхий захиргааныхаа хаяг болон түүний өөрчлөлтийг эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй;

15.14.хуульд заасан салбар, төлөөлөгчийн газар нээхтэй холбогдсон журам зөрчсөн;

15.15.эрх бүхий албан тушаалтныг томилох журам зөрчиж эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр томилсон;

15.16.үйл ажиллагааны шалгалтын тайлантай холбогдуулан хариу шаардсан тохиолдолд тайланг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 14 өдрийн дотор, эсхүл тайланд тусгайлан заасан хугацаанд эрх бүхий байгууллагад хариу мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

15.17.эрх бүхий байгууллагаас хууль тогтоомжид заасан бүрэн эрхээ хэрэгжүүлэх зорилгоор, эсхүл гадаадын зохицуулах

байгууллагын тавьсан хүсэлтийн дагуу мэдээлэл, баримт бичгээр хангахыг даалгасан мэдэгдлийг хүлээн авсан боловч биелүүлээгүй;

15.18.эрх бүхий байгууллагаас өгсөн даалгаврыг биелүүлээгүй;

15.19.дүрмийн сангийн доод хэмжээ хуульд заасан хэмжээнд хүрэхгүй болсон тохиолдолд эрх бүхий байгууллагад даруй бичгээр мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

15.20.төлбөрийн чадвар хуульд заасан үзүүлэлтэд хүрэхгүй болсон тохиолдолд эрх бүхий байгууллагад даруй бичгээр мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

15.21.өөрийн актуарчийг томилсон, эсхүл чөлөөлсөн тухай бүрд эрх бүхий байгууллагад ажлын 5 өдрийн дотор бичгээр мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

15.22.өөрийн эрх бүхий албан тушаалтны бүрэн эрх дуусгавар болсон, эсхүл хүсэлтээрээ чөлөөлөгдсөн тохиолдолд энэ тухай ажлын 5 өдрийн дотор эрх бүхий байгууллагад бичгээр мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16.Аудитор нь даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан даатгагч дүрмийн сангийн доод хэмжээ, компанийн хувьцаа, төлбөрийн чадварын шалгуур үзүүлэлт, даатгалын нөөц сан, ногдол ашиг хуваарилах, урьдчилгаа, эсхүл зээлтэй холбоотой хязгаарлалтыг ямар нэг хэлбэрээр зөрчсөн гэж үзсэн дүгнэлтийг эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

17.Актуарч нь:

17.1.өөрийн үйл ажиллагаандаа даатгалын багц дүрэмд заасан актуарын стандартыг дагаж мөрдөөгүй;

17.2.даатгагчийн санхүүгийн байдал, нөөцийн сан, төлбөрийн чадвар, даатгагч болон даатгуулагчийн ашиг сонирхолд нөлөөлж болох аливаа асуудлаар шаардлагатай арга хэмжээ авах талаар даатгагчид мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**24/11.21 дүгээр зүйлийн тайлбар:**





“Энэ зүйлийн 18 дахь хэсэгт заасан гаалийн болон бусад татварыг хугацаанд нь төлөөгүй бол төлөгдөөгүй татварын дүнгээс тооцон хугацаа хожимдуулсан хоног тутам 0,3 хувийн хүү ногдуулах ба уг хүүний хэмжээ нөхөн төлүүлэх татварын дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна. Энэ тайлбарт заасан “хүү” нь Иргэний хуульд заасан “анз”-д хамаарахгүй.”

### **25/11.32 дугаар зүйл:**

#### **“11.32 дугаар зүйл.Үндэсний төлбөрийн системийн тухай хууль зөрчих**

1.Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар хориглосон үйл ажиллагааг эрхэлсэн бол тухайн мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхийг хасаж хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний акт, эсхүл тэдгээрийг хэрэгжүүлэх талаар хуулиар эрх олгосон этгээдийн гаргасан шийдвэрийг биелүүлээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Үндэсний төлбөрийн системийн тухай хуульд заасан системийн тасралтгүй, найдвартай ажиллагаанд саад учруулсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Үндэсний төлбөрийн систем, түүний үйл ажиллагаанд хяналт тавих, шалгалт хийх үйл ажиллагаанд саад учруулсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Төлбөрийн болон төлбөр тооцооны баримтыг нуун дарагдуулсан, эсхүл төлбөр тооцоог саатуулсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Тайлан, мэдээ, баримтыг Монголбанканд хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актад заасны дагуу гаргаж өгөөгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Үндэсний төлбөрийн системийн тухай хуулиар тогтоосон шаардлагыг хангаагүй бол зөвшөөрөл эзэмшигчийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулсан тайлан мэдээлэл нийтлүүлсэн бол хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Хуурамч, худал, ташаа мэдээлэл агуулсан тайлан мэдээллийг баталгаажуулсан бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10.Төлбөрийн үйлчилгээ үзүүлэгч, оператор, төлбөрийн үйлчилгээ үзүүлэхтэй хамаарал бүхий этгээд, гэрээт төлөөлөгч эрхэлж байгаа өөрийн үйл ажиллагааны тухай хуурамч, худал, ташаа мэдээлэл бүхий зар сурталчилгааг түгээсэн бол хуулийн этгээдийг нэг зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11.Энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан зар сурталчилгааг түгээх эрх олгосон бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **26/12.4 дүгээр зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Гэрээт мэргэжлийн байгууллага нь оршин суугчдыг ус, дулаан, цахилгаанаар хангах зэрэг үйлчилгээний төлбөр, шимтгэлтэй холбогдсон санхүүгийн тайланг тухайн оршин суугчдад жил бүр тайлагнаагүй бол хуулийн этгээдийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **27/12.8 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Эрчим хүчний тухай хуульд заасныг зөрчиж шугам сүлжээний хамгаалалтын зурвасын дотор:

6.1.гэр, орон сууц, барилга байгууламж барьсан;

6.2.шугам сүлжээ өмчлөгч, эзэмшигчийн зөвшөөрснөөс бусад үйл ажиллагаа явуулсан бол үйл ажиллагааг зогсоож, барилга байгууламжийг буулгуулах, зурвасыг чөлөөлүүлэх арга хэмжээ авч учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **28/12.12 дугаар зүйл:**

##### **“12.12 дугаар зүйл.Сэргээгдэх эрчим хүчний тухай хууль зөрчих**

1.Дамжуулагч нь үйлдвэрлэгчээс нийлүүлсэн цахилгаан эрчим хүчийг эрчим хүчний дамжуулах сүлжээний хуваарилах байгууламжид техникийн шаардлагын дагуу холбох, өргөтгөл хийх, түүний зардлыг



хариуцах үүргээ биелүүлээгүй бол дамжуулагчийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

### **29/13.9 дүгээр зүйл:**

#### **“13.9 дүгээр зүйл. Мал, амьтны эрүүл мэндийн тухай хууль зөрчих**

1. Нийтийн хэрэгцээнд зориулан мал эмнэлэг, ариун цэвэр, эрүүл ахуйн шаардлага хангахгүй орчинд мал төхөөрсөн бол зөрчлийг арилгуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Мал эмнэлгийн холбогдолтой журам, заавар зөрчсөний улмаас өвчин тархах, малын гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүй байдал алдагдах, мал, амьтныг тарчлаан зовоох нөхцөл байдал үүссэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь дархлаажуулалт хийх, сорьц авах үед болон мал, амьтанд халдварт өвчний шинж тэмдэг илэрсэн, тодорхой бус шалтгаанаар хорогдсон тохиолдолд авч хэрэгжүүлэхээр хуульд заасан үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Малчин, амьтан маллагч, мал, амьтан өмчлөгч нь малын эмийн улсын бүртгэлд бүртгэгдээгүй эм хэрэглэсэн бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

#### **5. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь:**

5.1. өвчний сэжиг илэрсэн хот айл, эрчимжсэн аж ахуйн бүх малд нэн даруй эрүүл мэндийн үзлэг хийж, анхны онош тогтоогоогүй, эсхүл халдварт өвчний сэжигтэй мал, амьтанд тусгайлсан тэмдэг тавьж хяналтад аваагүй;

5.2. анхны оношийг баталгаажуулах зорилгоор зохих журам, зааврын дагуу сорьц авч хуульд заасан хугацаанд мал эмнэлгийн тасагт хүргүүлээгүй бол хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

#### **6. Мал эмнэлгийн үйлчилгээний нэгж нь:**



6.1.хуульд заасныг зөрчиж малын халдварт, гоц халдварт, шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг товлосон хугацаанд хэрэгжүүлээгүй;

6.2.мэргэжлийн үйлчилгээ эрхлэх итгэмжлэлгүй этгээд, мэргэжлийн үнэмлэхгүй техникийн ажилтнаар мал эмнэлгийн үйлчилгээг гүйцэтгүүлсэн бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Мэргэжлийн үйлчилгээ эрхлэх эрхгүй этгээд, мэргэжлийн үнэмлэхгүй техникийн ажилтан мал эмнэлгийн үйлчилгээ эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Аймаг, нийслэл, сум, дүүргийн лаборатори нь:

8.1.малын гаралтай хүнсний болон хүнсний бус түүхий эд, бүтээгдэхүүний аюулгүйн үзүүлэлтийг стандартад заасан аргачлалын дагуу хийгээгүй;

8.2.магадлан шинжилгээний гэрчилгээг шинжилгээ хийлгүй олгосон бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

### **30/14.7 дугаар зүйлийн 57 дахь хэсэг:**

“57.Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг даргаас харьяа нутаг дэвсгэртээ Монгол Улсын хууль тогтоомж, Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн бол хүнийг хорин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

### **31/14.11 дүгээр зүйл:**

#### **“14.11 дүгээр зүйл.Усан замын тээврийн тухай хууль зөрчих**

1.Тээвэрлэгч хуульд заасан үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Зорчигч нь:

2.1.усан замын тээврийн хэрэгслээр зорчихдоо бусдын амь нас, эрүүл мэндэд аюул, гэм хор учруулж болзошгүй эд зүйлийг авч явахгүй байх;



2.2.усан замын тээврийн хэрэгслээр зорчихдоо тээврийн хэрэгслийг эвдэж, гэмтээхгүй, байгаль орчныг бохирдуулахгүй байх;

2.3.усан замын тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх зорчигч бүр тасалбар авах;

2.4.усан замын тээврийн аюулгүй ажиллагааг хангах талаар мөрдөж байгаа хууль тогтоомж, дүрэм, журам, зааврыг болон эрх бүхий этгээдээс тавьсан хууль ёсны шаардлагыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх, биелүүлэх;

2.5.нийгмийн хэв журам, усан замын тээврийн хэрэгсэл дээр үйлчилж байгаа дотоод дэглэм журмыг сахин биелүүлэх үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Усан замын тээврийн хэрэгслийг бүртгүүлж, гэрчилгээ аваагүй, техникийн хяналтын үзлэгт хамрагдаагүй тээврийн хэрэгслээр тээвэрлэлт хийсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хорин таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Усан замын тээврийн хэрэгслийн ахмад, багийн гишүүд, өмчлөгч, эзэмшигч, жолооч нь согтууруулах ундаа, мансууруулах үйлчилгээтэй эм, бодис хэрэглэсэн үедээ усан замын тээврийн хэрэгсэл жолоодсон нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхийг нэг жил хүртэл хугацаагаар хасаж хүнийг арван таван нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Усан замын тээврийн хэрэгслийн ахмад, багийн гишүүд, өмчлөгч, эзэмшигч, жолооч нь:

5.1.согтууруулах ундааны зүйл уусан эсэхээ усан замын тээврийн хяналтын улсын байцаагч, бусад эрх бүхий албан тушаалтанд шалгуулахаас зайлсхийсэн;

5.2.зорчигч, аялагч тээвэрлэж явах үедээ тэдний анхаарал, сонирхлыг татах зорилгоор усны мандалд огцом эргэлт хийх, элдэв төрлийн хууль бус үзүүлбэр үзүүлсэн;

5.3.аврах хантаазгүй болон шаардлага хангахгүй аврах хантаазтай зорчигч, аялагчийг тээвэрлэсэн;

5.4.хөдөлгөөнд оролцохдоо бусад усан замын тээврийн хэрэгслийн хөдөлгөөний аюулгүй байдалд аюул учруулахаар гүйцэж түрүүлэх, буруу талаар зөрж өнгөрөх, хөдөлгөөний чиглэлийг нь сүлжих,

урдуур хойгуур нь тойрох зэргээр бусад тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулсан;

5.5.усан замын тээврийн хэрэгсэл жолоодох эрхгүй этгээдээр жолоодуулсан;

5.6.арван зургаа хүртэлх насны хүүхдийг асран хамгаалагч, харгалзан дэмжигчгүйгээр тээвэрлэсэн;

5.7.усан замын тээврийн хэрэгслийн зориулалт, үйлдвэрлэгчээс тогтоосон хөдөлгүүрийн хүчин чадлыг нэмэгдүүлж өөрчилсөн;

5.8.бүрэн бус, эвдрэл гэмтэлтэй усан замын тээврийн хэрэгслээр хөвөлтөд гаргасан бол зөрчлийг арилгуулж хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **32/14.12 дугаар зүйл:**

##### **“14.12 дугаар зүйл.Төрийн тусгай хамгаалалт тогтоосон бүсийн агаарын зайн дэглэм зөрчих**

1.Төрийн тусгай хамгаалалтын байгууллагаас тогтоосон дэглэм зөрчиж, төрийн тусгай хамгаалалтын бүсийн агаарын зайд нисгэгчгүй, зайнаас удирддаг агаарын хөлгөөр нислэг үйлдсэн бол зөрчлийг арилгуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **33/15.30 дугаар зүйл:**

##### **“15.30 дугаар зүйл.Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль зөрчих**

1.Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээдэд өмчлөгчийн төлөөлөгчийн ажил үүрэг гүйцэтгэхээ больсноос хойш хоёр жилийн хугацаанд хуульд заасан хориглосон үйл ажиллагааг явуулсан бол зөрчсөн хүнээр хууль бусаар хүлээн авсан бэлэг, үйлчилгээний үнэ хөлсийг төлүүлж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын дээд шүүхийн шүүгч, Улсын ерөнхий прокурор, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга, аймаг, нийслэлийн Засаг дарга, аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн дарга,



яамны Төрийн нарийн бичгийн дарга, Засгийн газрын агентлагийн дарга, төрийн өмчит компани, олон улсын байгууллагын дарга, захирлын албан тушаал эрхэлж байсан болон эрхэлж байгаа хүн, эсхүл түүнтэй хамаарал бүхий этгээд нь нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд нээлттэй тендер шалгаруулалтаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд төрийн болон орон нутгийн хэрэгцээнд бараа, ажил, үйлчилгээ худалдан авагч, төрийн санхүүгийн нөөц бүрдүүлэгч, төрөөс баталгаа гаргасан зээл хүртэгч аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч, эсхүл эдгээрийг гүйцэтгэж байгаа хувиараа аж ахуй эрхлэгч болсон бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Нийтийн албанаас чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд албан үүргээ гүйцэтгэж байх хугацаандаа төрийн бараа, ажил, үйлчилгээ худалдан авах, улсын болон орон нутгийн нөөцийн хуваарилалт, удирдах, хянах, хариуцлага хүлээлгэх зэрэг асуудлаар шийдвэр гаргаж байсан аж ахуйн нэгжийн хувь, хөрөнгө эзэмшигч, хамтрагч болох, тус аж ахуйн нэгжээс хөрөнгө шилжүүлж авсан бол байгуулсан гэрээ, контракт, авсан зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Албан үүргээс чөлөөлөгдсөнөөс хойш хоёр жилийн хугацаанд ашиг сонирхлын зөрчил үүсэж болох хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан бол байгуулсан гэрээ, контракт, авсан зөвшөөрлийг хүчингүй болгож хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**2 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “Мансуурсан” гэсний дараа “нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй” гэж, 5.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “газарт” гэсний дараа “, эсхүл орон байранд” гэж, 5.4 дүгээр зүйлийн тайлбарын “гэж” гэсний дараа “хууль,” гэж, 5.11 дүгээр зүйлийн 1.9 дэх заалтын “бол” гэсний дараа “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгслийг хурааж,” гэж, 5.15 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “үйлдвэрлэх,” гэсний дараа “дамжуулах, түгээх, хангах,” гэж, 6.2 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг, мөн зүйлийн 7.3 дахь заалт, мөн зүйлийн 8, 9 дэх хэсгийн “бол” гэсний дараа “зөрчлийг арилгуулж,” гэж, 6.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “эмнэлгийн хэрэгсэл” гэсний дараа “, биологийн идэвхт бүтээгдэхүүн” гэж, мөн хэсгийн тайлбарын “бүсээс” гэсний өмнө “хяналтын” гэж, мөн зүйлийн 10.5 дахь заалтын “гүйцэтгэсэн бол” гэсний дараа “зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг хурааж,” гэж, мөн зүйлийн 11 дэх хэсгийн “худалдсан бол” гэсний дараа “зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг хурааж” гэж, 6.10 дугаар зүйлийн 1, 3, 4, 5 дахь хэсгийн “эд” гэсний өмнө “эс,” гэж, 6.14 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “импортолсон бол” гэсний дараа “зөрчилтэй хүнсний бараа, бүтээгдэхүүнийг хурааж,” гэж, 6.15 дугаар зүйлийн 3.2 дахь заалтын “борлуулсан” гэсний дараа “, үйлчилсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсгийн “буцаан” гэсний дараа “аваагүй, эсхүл” гэж, 7.6 дугаар зүйлийн

4 дэх хэсгийн “агнасан” гэсний дараа “, тээвэрлэсэн” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “нутагшуулсан” гэсний дараа “, өсгөж үржүүлсэн” гэж, 7.7 дугаар зүйлийн 1.2 дахь заалтын “худалдсан бол” гэсний дараа “хууль бусаар бэлтгэсэн эд зүйлийг хурааж” гэж, 7.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “бол” гэсний дараа “зөрчил үйлдэж олсон хөрөнгө, орлогыг хурааж,” гэж, мөн зүйлийн 2.3 дахь заалт, 10 дахь хэсгийн “бол” гэсний дараа “учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж” гэж, 8.1 дүгээр зүйлийн 14 дэх хэсгийн “гэрээг цуцалж” гэсний дараа “, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэж, 10.2 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “учирсан бол” гэсний дараа “учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэж, 10.7 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн “хурааж” гэсний дараа “тухайн” гэж, мөн зүйлийн 8, 9 дэх хэсгийн “бараа” гэсний өмнө “тухайн” гэж, 10.13 дугаар зүйлийн 3.3 дахь заалтын “байгууллагад” гэсний дараа “цуцлагдсан, эсхүл сунгасан гэрээний тухай мэдээллийг” гэж, АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛГИЙН гарчгийн “ТАТВАР,” гэсний дараа “МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТ, гэж, 11.15 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “хохирогчид” гэсний дараа “бичгээр” гэж, 12.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “бол” гэсний дараа “зөрчлийг арилгуулж, анхны зураг төсөлд нийцүүлж” гэж, 14.5 дугаар зүйлийн 15 дахь хэсгийн “цагаар” гэсний дараа “эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр” гэж, 15.2 дугаар зүйлийн тайлбарын “тагнуул,” гэсний дараа “гааль,” гэж, мөн тайлбарын “алба хаагчийн” гэсний өмнө “болон авлигатай тэмцэх, хил хамгаалах, гадаадын иргэн, харьяатын асуудал эрхэлсэн байгууллагын” гэж, 15.14 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “Төрийн” гэсний дараа, мөн зүйлийн 1.1, 1.2, 1.3, 1.4 дэх заалтын “төрийн” гэсний дараа “болон албаны” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

### **1/5.7 дугаар зүйл:**

#### **“5.7 дугаар зүйл.Мөрийтэй тоглоом тоглох**

1.Олон нийтийн газар ашиг олох зорилгоор шоо, хөзөр, бусад эд зүйл ашиглан үр дүнг нь урьдчилан төсөөлөх боломжгүй, аз туршиж тоглодог мөрийтэй тоглоом тоглосон бол зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **2/5.11 дүгээр зүйлийн 4, 5 дахь хэсэг:**

“4.Химийн хорт, аюултай бодистой холбогдсон үйл ажиллагааг эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр явуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж





хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Химийн хорт, аюултай бодисын хүний эрүүл мэнд, байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийн хүлцэх хэмжээний талаарх стандартыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

### **3/6.1 дүгээр зүйл:**

#### **“6.1 дүгээр зүйл.Хог хаягдлын тухай хууль зөрчих**

##### **1.Аюултай хог хаягдлыг:**

- 1.1.түр хадгалах;
- 1.2.цуглуулах;
- 1.3.тээвэрлэх;
- 1.4.дахин боловсруулах;
- 1.5.устгах;
- 1.6.бүртгэх;
- 1.7.тайлагнах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

##### **2.Тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг:**

- 2.1.цэвэрлэх;
- 2.2.цуглуулах;
- 2.3.ангилах;
- 2.4.тээвэрлэх;
- 2.5.дахин боловсруулах;
- 2.6.сэргээн ашиглах;
- 2.7.устгах;
- 2.8.булшлах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

##### **3.Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг:**

- 3.1.ангилах;
- 3.2.цуглуулах;
- 3.3.тээвэрлэх;
- 3.4.дахин боловсруулах;
- 3.5.сэргээн ашиглах;

3.6.устгах журам, аргачлал, зааврыг зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Харьяа нэгж, байгууллагад үүссэн болон цэргийн зориулалтаар ашиглаж байсан газарт үлдсэн галт зэвсэг, сум, галт хэрэглэл, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис, тэдгээрийн үлдэгдлийг:

- 4.1.цуглуулах;
- 4.2.тээвэрлэх;
- 4.3.дахин боловсруулах;
- 4.4.сэргээн ашиглах;

4.5.устгах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг:

- 5.1.ангилах;
- 5.2.цуглуулах;
- 5.3.тээвэрлэх;
- 5.4.дахин боловсруулах;
- 5.5.сэргээн ашиглах;

5.6.устгах журам зөрчсөн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Энгийн хог хаягдлыг:

- 6.1.цэвэрлэх;
- 6.2.ангилах;
- 6.3.цуглуулах;
- 6.4.тээвэрлэх;
- 6.5.дахин боловсруулах;
- 6.6.сэргээн ашиглах;
- 6.7.устгах;

6.8.булшлах журам зөрчсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдлын талаар хуульд заасан:

- 7.1.энгийн хог хаягдлаа ангилан ялгах;



7.2. хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях, эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх;

7.3. үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх;

7.4. хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх;

7.5. эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх;

7.6. нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;

7.7. барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8. Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолой, эсхүл нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хаясан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9. Хог хаягдлыг ил задгай шатаасан, эсхүл гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаасан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

10. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хуулийн этгээдийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

11. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулсан, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

12.Хуульд заасны дагуу гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөх үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

13.Хуульд заасны дагуу тогтоосон хуваариар хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

14.Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

15.Хуульд заасны дагуу гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ аваагүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

16.Хуульд заасны дагуу гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагааг эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гучин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

17.Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлал, зуслан, орон сууц, олон нийтийн бүс, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, хүн амын унд, ахуйн усан хангамжийн тэжээгдлийн мужийн дотор, ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон болон бусад хууль тогтоомжоор хориглосон газарт энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламж байгуулсан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

18.Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг тухайн аймаг, нийслэлийн Засаг



даргаас олгосон зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

19.Хог хаягдлын төвлөрсөн цэгт аюултай хог хаягдал, халдвартай хог хаягдал, эсхүл шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал булшилсан, шатаасан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

20.Тогтоосон цэгээс бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулсан, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

21.Аж ахуйн нэгж, байгууллага нь аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

22.Аюултай хог хаягдал хадгалах, устгах байгууламжийг хуулиар байгуулахыг хориглосон байршилд байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

23.Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

24.Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг хуульд заасан шаардлагын дагуу эрхлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

25.Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хуульд заасны дагуу холбогдох мэдээллийг

байгууламжийг хааснаас хойш 10 жил хадгалах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

26.Нийтийн эдэлбэр газар, эсхүл ногоон бүсэд энгийн хог хаягдал хаясан бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

27.Аюултай хог хаягдлын жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

28.Үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг цуглуулж, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах, экспортлох амьдралын мөчлөгийг харуулсан схемтэй байх, эсхүл түүнийг олон нийтэд нээлттэй байлгах үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **4/6.10 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Хуульд зааснаас бусад тохиолдолд амьгүй донороос эс, эд, эрхтэн авахдаа нас барагчийн гэрээслэл, эсхүл түүний төрсөн эцэг, эх, эхнэр, нөхөр, хамтын амьдрал бүхий гэр бүлийн насанд хүрсэн гишүүний зөвшөөрлийг бичгээр аваагүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **5/6.15 дугаар зүйлийн 1.2 дахь заалт:**

“1.2.хуульд заасан дүгнэлт гаргуулаагүй;”

#### **6/6.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Хүнсний үйлдвэрлэл, худалдаа, үйлчилгээнд мөрдөх техникийн зохицуулалтыг зөрчсөн бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний



төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **7/6.19 дүгээр зүйл:**

##### **“6.19 дүгээр зүйл.Биеийн тамир, спортын тухай хууль зөрчих**

1.Сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагаанд стандарт, сургалт-дасгалжуулалтын хөтөлбөрийг мөрдөөгүй, хичээллэгчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулаагүй бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагааг зохих журмын дагуу эрх авалгүй эрхэлсэн, эсхүл эрх аваагүй этгээдээр сургалт-дасгалжуулалтыг удирдуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Спортын сургалт-дасгалжуулалтын үйл ажиллагааг зохих журам, стандартын дагуу эрхлээгүй бол дасгалжуулагчийн эрхийг хасаж нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Улсын хэмжээний спортын тэмцээний нэгдсэн хуваарьт заагдаагүй спортын тэмцээн зохион байгуулсан бол хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Орон нутгийн чанартай спортын тэмцээнийг урьдчилан мэдэгдэлгүйгээр зохион байгуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Орон нутгийн чанартай спортын тэмцээнийг зохион байгуулахад спортын тэмцээн зохион байгуулах дүрэм, стандартын талаар танилцуулаагүй, оролцогчийн эрүүл мэндийн байдалд хяналт тавих үйл ажиллагааг зохион байгуулаагүй, аюулгүй байдлыг хангаагүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Допингийн эсрэг үндэсний дүрмийг зөрчсөн бол спортын тэмцээнд оролцох эрхийг хоёр жил хүртэл хугацаагаар хасаж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **8/6.20 дугаар зүйл:**

##### **“6.20 дугаар зүйл.Хүүхдийн эрхийг зөрчих**

1.Эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, эсхүл хуулиар асран хамгаалах үүрэг хүлээсэн хүн, хуулийн этгээд:

1.1.хүүхдийг хувцас, хоол хүнс, орон байраар зориуд гачигдуулсан;

1.2.хүүхдэд эрүүл ахуйн шаардлагад нийцээгүй хоол хүнсний зүйлийг хэрэглүүлсэн;

1.3.хүүхдийг дархлаажуулалтад хамруулах үүргээ биелүүлээгүй;

1.4.хуулиар хүлээсэн асран хамгаалах, тэжээн тэтгэх үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Хүн, хуулийн этгээд нь:

2.1.хүүхдэд утаат тамхи татахыг санал болгосон, бэлэглэсэн, эсхүл утаат тамхи олж авах, хэрэглэхэд дэмжлэг үзүүлсэн;

2.2.хууль тогтоомжид заасны дагуу өмчлөх, өв залгамжлах, эсхүл ажил үйлчилгээний хөлс, урамшуулал авах эрхийг хязгаарласан;

2.3.хүүхдийн сурч боловсрох, хөгжих, эрүүл аюулгүй орчинд амьдрах эрхийг хязгаарласан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Хүүхдийг:

3.1.аливаа төлбөр, хураамжийг төлөөгүй үндэслэлээр хүүхдийн сурч боловсрох эрхийг хууль бусаар хязгаарласан;

3.2.өөрийнх нь болон эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигчийн зөвшөөрөлгүйгээр гэрэл зураг, дууны, дүрсний, дуу-дүрсний бичлэгийг мэдээлэл, сурталчилгаанд ашигласан;

3.3.өөрт ашигтай байдал бий болгох зорилгоор хууль бусаар хүүхдийн нэрийг барьж, ашиг олох, эсхүл амь нас, эрүүл мэнд, нэр хүндэд нь харшлах, аюул учруулах тоглоом, наадам, бусад арга хэмжээнд оролцуулсан бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Хүүхдийн хүсэл зоригийн эсрэг шашны үйл ажиллагаанд татан оролцуулсан бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.





5.Сургууль, сургуулийн дотуур байр, өдөр өнжүүлэх төв, асрамж, халамжийн төв, хүүхэд хамгааллын төв болон хүүхдэд үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бусад байгууллага нь хүүхдэд аюулгүй, ээлтэй орчин бүрдүүлэх үүргээ биелүүлээгүйгээс хүүхдийн эрх зөрчигдсөн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Тэтгэлэг төлөгч шүүхийн шийдвэрээр сар бүр төлбөл зохих хүүхдийн тэтгэмжийг гурван сараас дээш хугацаанд төлөөгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.

7.Хүүхдийн бие махбодод халдсан, эсхүл үл хайхарсан, эсхүл хүүхдийн дэргэд архи дан согтуурсан, мансуурсан, хүчирхийлэл үйлдсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

8.Хүүхдийн амь нас, эрүүл мэнд, хөгжилд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй эрсдэлт нөхцөлөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах, мэдэгдэх, хүчирхийллээс үүдэлтэй эсэхийг шалгах үүргээ биелүүлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

#### **9/7.9 дүгээр зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Ойн дагалт нөөцийг менежментийн төлөвлөгөөнд туссан хэмжээнээс хэтрүүлэн ашигласан, бэлтгэсэн бол хэмжээнээс хэтрүүлэн бэлтгэсэн эд зүйлийг хурааж хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **10/7.11 дүгээр зүйлийн 2.2 дахь заалт:**

“2.2.хайгуулын, ашиглалтын талаар хуульд заасан мэдээ, тайлан, төлөвлөгөөг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл хуурамч мэдээ, тайлан гаргасан бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **11/10.17 дугаар зүйл:**

**“10.17 дугаар зүйл.Нийгмийн даатгалын тухай хууль зөрчих**

1. Ажил олгогч хуульд зааснаар албан журмын нийгмийн даатгалд хамрагдаагүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2. Ажил олгогч нь нийгмийн даатгалын шимтгэл төлөхөөс зайлсхийх зорилгоор шимтгэл ногдох орлогыг нуусан, эсхүл хэмжээг нь санаатайгаар бууруулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3. Нийгмийн даатгалын шимтгэл төлөгч нь нийгмийн даатгалын шимтгэлийг эрх бүхий байгууллагын тогтоосон хугацаанд төлөөгүй бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4. Ажил олгогч нь тухайн сарын нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тайланг хуульд заасан хугацаанд ирүүлээгүй, тайлагнаагүй бол хуулийн этгээдийг хоёр зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5. Ажил олгогч нь тухайн аж ахуйн нэгж, байгууллагад ажил, хөдөлмөр эрхлээгүй, хөдөлмөрийн харилцаа үүсээгүй хүнд шимтгэл төлсөн, эсхүл үндэслэлгүйгээр цалин хөлсийг өсгөж, нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж авсан бол учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6. Нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг зориулалт бусаар ашигласан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7. Банк, санхүүгийн байгууллага тэтгэвэр, тэтгэмжийг хугацаанд нь олгоогүй саатуулсан бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

Тайлбар: Энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан нуусан, эсхүл санаатайгаар бууруулсан орлогод төлбөл зохих шимтгэлтэй тэнцэх хэмжээний алданги тооцох ба уг алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

-Энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан нийгмийн даатгалын шимтгэлийг хуульд заасан хугацаанд төлөөгүй бол шимтгэлийн дүнгээс хугацаа



хэтрүүлсэн хоног тутамд 0,3 хувьтай тэнцэх хэмжээний алданги тооцох ба уг алдангийн хэмжээ нь төлбөл зохих шимтгэлийн 50 хувиас хэтрэхгүй байна.

-Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан зөрчлийг үйлдсэн банк, санхүүгийн байгууллага нь сарын тэтгэвэр, тэтгэмжийн дүнгээс саатуулсан хоног тутамд алданги төлөх ба уг алдангийн хэмжээ нь тэтгэвэр, тэтгэмж авагчийн үйлчлүүлдэг банкны иргэдийн хугацаатай хадгаламжийн тухайн үеийн хүүгээр бодогдоно.

-Хуульд заасны дагуу сайн дураар даатгуулагчид энэ зүйлийн 3, 7 дахь хэсэг хамаарна.”

### **12/10.22 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Хуульд заасан журмын дагуу гэрчилгээг хүчингүй болгоогүй, эсхүл гэрчилгээг хүчингүйд тооцох хуулиар тогтоосон нөхцөлийн дагуу гэрчилгээг хүчингүйд тооцоогүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

### **13/11.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч хуурамч, худал, ташаа мэдээлэл бүхий зар сурталчилгааг тараасан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

### **14/11.10 дугаар зүйлийн 2, 4 дэх хэсэг:**

“2.Хүн, хуулийн этгээд:

2.1.нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд бүртгүүлээгүй, эсхүл хязгаарлагдмал хариуцлагатай компанийн хувьцааг нийтэд санал болгосон;

2.2.үнэт цаас гаргагч нь үнэт цаасны арилжаанаас төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийг тухайн үнэт цаасны танилцуулгад зааснаас өөр зориулалтаар зарцуулсан;

2.3.хуульд зааснаас өөр этгээд өөрийн оноосон нэртэй “Үнэт цаасны компани” гэсэн дэлгэрэнгүй тэмдэглэгээ, эсхүл “ҮЦК” гэсэн товчилсон тэмдэглэгээ хэрэглэсэн;

2.4.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд, эсхүл хүчингүй болгосны дараа тухайн хуулийн этгээдийн харилцагчийн эрх ашгийг хамгаалах зорилгоор эрх бүхий байгууллагын зөвшөөрснөөс бусад аливаа гэрээ, хэлцэл, гүйлгээ хийсэн;

2.5.хөрөнгө оруулалтын сан хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан;

2.6.үнэт цаасны өмчлөх эрхийн бүртгэлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд нь өөрийн үнэт цаасны бүртгэлд байгаа үнэт цаасыг өмчлөгчийнх нь зөвшөөрөлгүйгээр дур мэдэн захиран зарцуулсан;

2.7.кастодианы үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээд өөрт хадгалагдаж байгаа үнэт цаасны талаар өмчлөгчөөс бусад аливаа этгээдтэй гэрээ, хэлцэл байгуулсан, эсхүл захиран зарцуулсан;

2.8.кастодианы үйл ажиллагаа эрхэлж байгаа этгээдийн бусдын өмнө хүлээсэн үүргийг түүний харилцагчийн дансан дахь үнэт цаас болон мөнгөн хөрөнгөөр гүйцэтгэсэн;

2.9.хөрөнгийн бирж энэ хуулиар хориглосон үйл ажиллагаа эрхэлсэн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гучин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Үнэт цаасны зах зээлийн оролцогч, зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэгч, аудитор эрх бүхий байгууллага бүрэн эрхээ хэрэгжүүлэх, эсхүл гадаад улсын эрх бүхий зохицуулагч байгууллага, эсхүл олон улсын байгууллагын хүсэлтэд заасан шаардлагатай мэдээллийг тогтоосон хугацаанд, шаардсан хэлбэрээр баталгаажуулж ирүүлэхийг зохицуулалттай этгээд, үнэт цаас гаргагч, тэдгээрийн холбогдох этгээд, эсхүл тухайн нөхцөл байдалтай холбоотой аливаа этгээдээс бичгээр шаардсаныг биелүүлээгүй бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

### **15/11.13 дугаар зүйлийн 3, 4, 6, 9 дэх хэсэг:**

“3.Хуульд заасныг зөрчиж даатгагч өөрийн эзэмшил, өмчлөлд байгаа энэ хэсэгт заасан хөрөнгийн талаар эрх бүхий байгууллагаас бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр хуулиар хориглосон үйлдэл хийсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

#### **4.Даатгагч:**

4.1.хуулиар хориглосон үйл ажиллагаа явуулсан;

4.2.хуульд заасан шаардлагыг хангаагүй аудиторыг санхүүгийн тайлангаа баталгаажуулах зорилгоор томилсон;



4.3.урт хугацааны даатгагч хуульд заасны дагуу өөрийн актуарчийг томилоогүй, эсхүл хуульд заасан хугацаанд актуарын хяналт шалгалт хийлгээгүй;

4.4.зөвхөн даатгалын үйл ажиллагаа эрхлэх журам зөрчиж даатгалын үйл ажиллагаа, түүнтэй холбоогүй үйл ажиллагаа эрхэлсэн;

4.5.оноосон нэрийн ард “даатгал” гэсэн үгийг заавал хэрэглэх журам зөрчсөн;

4.6.даатгагч, түүний холбогдох этгээд үйл ажиллагааны шалгалтын үед хуулиар тогтоосон үүргээ биелүүлээгүй;

4.7.тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлсэн, эсхүл хүчингүй болгосон тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш эрх бүхий байгууллагаас бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр шинээр даатгалын гэрээ байгуулсан, эсхүл тухайн өдрөөс өмнө байгуулсан даатгалын гэрээг шинэчилсэн, эсхүл өөрчилсөн;

4.8.эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр даатгалын үйл ажиллагааг шилжүүлсэн, эсхүл нэгтгэсэн бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Аудитор нь даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан:

6.1.даатгагч төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болж болзошгүй байгаа;

6.2.даатгалын үйл ажиллагаатай холбоотой гэмт хэрэг үйлдсэн, эсхүл үйлдсэн байж болзошгүй;

6.3.даатгагч хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг ноцтойгоор зөрчсөн гэж үзсэн дүгнэлтийг эрх бүхий байгууллагад мэдэгдэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

9.Актуарч нь:

9.1.даатгагч хууль тогтоомж, даатгалын багц дүрмийг зөрчсөн, эсхүл зөрчсөн байж болзошгүй, эсхүл даатгагч хууль тогтоомж зөрчсөн нь даатгуулагчийн эрх ашигт ноцтой нөлөөлнө гэж үзсэн тухай даатгагчийн баримт материалд үндэслэн гаргасан дүгнэлтийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдээгүй;

9.2.хуульд заасны дагуу энэ зүйлийн 9.3 дахь заалтад заасныг даатгагчид мэдэгдсэн бөгөөд тогтоосон хугацаанд даатгагч ямар нэг арга хэмжээ аваагүй бол энэ тухай эрх бүхий байгууллагад даруй мэдэгдэх үүргээ биелүүлээгүй;

9.3.даатгагч түүнтэй байгуулсан гэрээгээ цуцалсан, эсхүл өөрөө ажиллах боломжгүй гэдгээ мэдэгдэж чөлөөлөгдсөн тохиолдолд эрх бүхий байгууллагад хуульд заасан асуудлаар мэдээлэл өгөхөөс татгалзсан бол хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **16/11.21 дүгээр зүйлийн 11 дэх хэсэг:**

“11.Тарифын болон тарифын бус хязгаарлалт тогтоосон барааг энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан аргаар гаалийн хилээр хууль бусаар нэвтрүүлсэн, эсхүл нэвтрүүлэхийг завдсан бол тухайн зөрчилд холбогдох барааг хурааж, эсхүл үнийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

#### **17/13.4 дүгээр зүйл:**

##### **“13.4 дүгээр зүйл.Малын генетик нөөцийн тухай хууль зөрчих**

1.Мэргэжлийн үйлчилгээ үзүүлэх итгэмжлэл, зэрэг дэвгүй этгээд мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээг гүйцэтгэсэн бол зөрчлийг арилгуулж, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд нь:

2.1.цөм сүргийн болон үржлийн малыг технологит хугацаанд үзлэг ангилалтад хамруулаагүй, ашиг шимт чанарыг үнэлүүлж, баталгаажуулаагүй;

2.2.үр, хөврөлийг мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээний нэгжийн хяналтын доор ашиглаагүй бол зөрчлийг арилгуулж, хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд нь:

3.1.эрхбүхиймэргэжлийнбайгууллагынзөвшөөрөлгүйгээр өөр үүлдрийн мал, эсхүл стандартын шаардлагад тэнцэхгүй хээлтүүлэгчийг сайжруулагчаар ашигласан;

3.2.тухайн бүс нутагт үржүүлэхийг зөвшөөрснөөс өөр үүлдэр, омгийн хээлтүүлэгчийг ашигласан бол хүнийг гурван зуун нэгжтэй



тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Малчин, мал бүхий этгээд, хуулийн этгээд нь малыг дахин давтагдахгүй хувийн дугаараар ялган тэмдэглүүлэх, нэгдсэн бүртгэлд хамруулах үүргээ биелүүлээгүй бол хүнийг тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Тусгай зөвшөөрөлгүйгээр шинээр малын үүлдэр, омог бий болгох, үр, өндгөн эс, хөврөлийг үйлдвэрлэх, үйлчилгээнд нэвтрүүлэх, бичил биетнийг өсгөвөрлөх үйл ажиллагааг эрхэлсэн бол хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

6.Тусгай зөвшөөрөл эзэмшигч нь:

6.1.тухайн жилд импортлохоор тогтоосон мал, үржүүлгийн бүтээгдэхүүний төрөл, тоо хэмжээг зөрчсөн;

6.2.малын үржүүлгийн бүтээгдэхүүнийг гадаадад гаргахад тухайн төрөл, зүйл, цуврал тус бүрийн сорьцын ижил хувийг малын үндэсний генийн санд байршуулаагүй бол хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

7.Мал үржүүлэг, технологийн ажил, үйлчилгээ эрхлэгч нь:

7.1.малын болон малын генетик нөөцөд хамааралтай уламжлалт мэдлэгийн бүртгэлийг хөтлөөгүй;

7.2.үржлийн малын удам гарваль, ашиг шим, зүс, галбир, бие цогцос, үр төлийн чанарын үнэлгээ хийгээгүй;

7.3.технологийн хугацаанд үржлийн малд үзлэг ангилалт, тохируулан сонголт хийх, өсвөр малыг үржилд шилж сонгох, цөм сүрэг бүрдүүлээгүй;

7.4.бог малын, шаардлагатай тохиолдолд бод малын хээлтүүлэгчийг сүргээс тусгаарлах, мал үржүүлэг, технологийн ажил үйлчилгээ үзүүлэх талаар хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

**4 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “Зөрчил үйлдсэн арван зургаагаас” гэснийг “Энэ хуульд өөрөөр заагаагүй бол зөрчил үйлдсэн арван дөрвөөс” гэж, 5.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “мэдэгдэлгүйгээр” гэснийг “бүртгүүлэлгүйгээр, эсхүл мэдэгдэл

хүргүүлснээс хойш хуульд заасан хугацаа өнгөрөөгүй байхад” гэж, 6.2 дугаар зүйлийн 12 дахь хэсгийн “хоёр зуун” гэснийг “нэг зуун” гэж, 6.5 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, үйл ажиллагааг зогсоож, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгож” гэснийг “зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйлийг хурааж” гэж, мөн зүйлийн 8 дахь хэсгийн “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл,” гэснийг “зөрчилтэй бараа, бүтээгдэхүүн, эд зүйл,” гэж, 6.6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн тайлбарын “хэрэгслийг” гэснийг “хэрэгсэл, биологийн идэвхт бүтээгдэхүүнийг” гэж, 6.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “журам” гэснийг “шаардлагыг” гэж, 6.17 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсгийн “үйл ажиллагааг зогсоож” гэснийг “зөрчилтэй бараа, бүтээгдэхүүнийг хурааж” гэж, 7.11 дүгээр зүйлийн 7.5 дахь заалтын “хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснийг “зөрчил үйлдэхэд ашигласан эд зүйл, хэрэгсэл, хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, 7.14 дүгээр зүйлийн 3.2 дахь заалтын “шатахууныг” гэснийг “шатахуун, тусгай шингэн, шатдаг хийг” гэж, 9.1 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “боловсрох, хүүхдээ сургахад нь дэмжлэг, туслалцаа үзүүлэх” гэснийг “боловсрох нөхцөл боломжийг бүрдүүлэх” гэж, 10.4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Зөвшөөрөлтэйгөөр” гэснийг “Хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагад бүртгүүлэх худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээг бүртгүүлээгүй, эсхүл зөвшөөрөлтэй” гэж, мөн зүйлийн 1, 2 дахь хэсгийн “тавин” гэснийг “хорин” гэж, “таван зуун” гэснийг “хоёр зуун” гэж, 10.7 дугаар зүйлийн 10 дахь хэсгийн тайлбарын “8 дахь” гэснийг “8, 9 дэх” гэж, 10.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Дүрэмд орсон” гэснийг “Хоршооны тухай хууль зөрчиж дүрэмд орсон” гэж, 11.3 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн “арван” гэснийг “хоёр” гэж, 11.10 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, мөн зүйлийн 10.3 дахь заалтын “хүнийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснийг “хүнийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, 11.10 дугаар зүйлийн 11 дэх хэсгийн, 11.13 дугаар зүйлийн 5, 10 дахь хэсгийн, 11.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсгийн “хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснийг “хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, 11.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “тооцоо, даатгал, даатгалын мэргэжлийн оролцогчийн” гэснийг “тооцооны” гэж, мөн хэсгийн “гурван зуун” гэснийг “дөрвөн мянган” гэж, “гурван мянган” гэснийг “дөчин мянган” гэж, 11.9 дүгээр зүйлийн 2.6 дахь заалтын “хүнийг зургаан зуун





нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснийг “хүнийг нэг зуун тавин нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянга таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, мөн зүйлийн 3.7 дахь заалтын “хүнийг таван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснийг “хүнийг нэг зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, 11.13 дугаар зүйлийн 7.2 дахь заалтын, мөн зүйлийн 8 дахь хэсгийн, 11.14 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “зургаан мянган” гэснийг “гурван мянган” гэж, мөн зүйлийн 5, 8 дахь хэсгийн “хүнийг дөрвөн зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснийг “хүнийг хоёр зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, мөн зүйлийн 6 дахь хэсгийн “хүнийг зургаан зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг зургаан мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэснийг “хүнийг гурван зуун нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг гурван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно” гэж, 11.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “сангийн төлөөлөгч,” гэснийг “сангийн төлөөлөгч нь” гэж, 11.21 дүгээр зүйлийн 17 дахь хэсгийн “энэ хуульд заасан” гэснийг “энэ зүйлд заасан бусад” гэж, 11.22 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “бол” гэснийг “, эсхүл нэвтрүүлэх оролдлого хийсэн бол хилээр нэвтрүүлэхийг хориглож” гэж, 12.9 дүгээр зүйлийн гарчгийн “хүчний” гэснийг “хүч” гэж, 12.11 дүгээр зүйлийн 1, 4 дэх хэсгийн “нь гурван сарын хугацаагаар түр, хэсэгчлэн” гэснийг “зөрчил арилтал түр” гэж, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хаагчийг” гэснийг “хаагч, эсхүл улсын байцаагчийн эрхтэй этгээдийг” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 6.5 дугаар зүйлийн 7.3 дахь заалтын “хэрэгсэл,” гэснийг болон “үйл ажиллагааг зогсоож,” гэснийг, 6.14 дүгээр зүйлийн 3.4 дэх заалтын “учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэснийг, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “, органик” гэснийг, 6.15 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж, учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэснийг, 7.11 дүгээр зүйлийн 5 дахь хэсгийн “, эсхүл олборлох үед ашигт малтмалын хаягдал, бохирдлыг тогтоосон хэм хэмжээнээс хэтрүүлсэн” гэснийг, 12.9 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 3.5 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 6.21 дүгээр зүйл, 7.11 дүгээр зүйлийн 2.3 дахь заалт, 11.12 дугаар зүйлийн 7 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Усан замын тээврийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“19 дүгээр зүйл.**Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

19.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

19.3.Усан замын тээврийн тухай хууль зөрчигчид торгох шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ТӨРИЙН БОЛОН АЛБАНЫ НУУЦЫН  
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ  
ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Төрийн болон албаны нууцын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсгийг 39.6, 39.7 дахь хэсэг болгож доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:



“39.6.Энэ хуулийн 39.5-д заасныг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

39.7.Төрийн болон албаны нууцын тухай хууль зөрчигчид торгох шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, зөрчлийн улмаас бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“43 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**

1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**НИЙГМИЙН ДААТГАЛЫН ТУХАЙ  
ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийгмийн даатгалын тухай хуулийн 20 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**“20 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид  
хүлээлгэх хариуцлага**

1.Тооцооны алдаа гаргаснаас шимтгэлийг дутуу төлсөн бол дутуу төлсөн шимтгэлийг нөхөн төлүүлж, уг шимтгэлийн дүнгээс тооцооны алдаа гарснаас хойших хугацааны хоног тутамд 0,1 хувийн алданги ногдуулах ба алдангийн нийт хэмжээ дутуу төлсөн шимтгэлийн 30 хувиас хэтрэхгүй байна.

2.Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын санд төлөх шимтгэлийн хувь хэмжээг буруу тооцсон бол дутуу төлсөн шимтгэлийг нөхөн төлүүлж, энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан алданги ногдуулна.

3.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

4.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.Нийгмийн даатгалын тухай хууль зөрчигчид алданги, торгох шийтгэл оногдуулсан нь тухайн зөрчлийг арилгах, бусдад учруулсан хохирлыг нөхөн төлөх хариуцлагаас чөлөөлөх үндэслэл болохгүй. Зөрчлийн тухай хуулийн 10.17 дугаар зүйлд заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэл болон алдангийн төлбөрийг нийгмийн даатгалын санд төвлөрүүлнэ.”

**2 дугаар зүйл.**Нийгмийн даатгалын тухай хуулийн 26 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 5 дахь заалтын “энэ” гэснийг “холбогдох” гэж өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

**ЗАМЫН ХӨДӨЛГӨӨНИЙ АЮУЛГҮЙ  
БАЙДЛЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ,  
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлд доор дурдсан агуулгатай 9.5 дахь хэсэг нэмсүгэй:

“9.5.Замын хөдөлгөөний түгжрэл, саатлыг зохицуулах зорилгоор аймаг, нийслэлийн Засаг дарга нь харьяа нутаг дэвсгэртээ Монгол



Улсын хууль тогтоомж, Замын хөдөлгөөний дүрэмд нийцүүлэн тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд хязгаарлалт тогтоосон захиргааны хэм хэмжээний акт гаргаж болно.

**2 дугаар зүйл.**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.3 дахь хэсгийн “Замын хөдөлгөөн зохицуулах, хянан шалгах” гэсний дараах “болон бэлэн бус хэлбэрээр торгууль оногдуулах,” гэснийг хассугай.

**3 дугаар зүйл.**Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4.2 дахь заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **НИЙТИЙН АЛБАНД НИЙТИЙН БОЛОН ХУВИЙН АШИГ СОНИРХЛЫГ ЗОХИЦУУЛАХ, АШИГ СОНИРХЛЫН ЗӨРЧЛӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсгийн 29.1.3 дахь заалтын “, 20.3, 20.5, 21.1” гэснийг хассугай.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### НӨХӨРЛӨЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Нөхөрлөлийн тухай хуулийн 18 дугаар зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

#### “18 дугаар зүйл.Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага

18.1.Энэ хуулийг зөрчсөн албан тушаалтны үйлдэл нь гэмт хэргийн шинжгүй бол Төрийн албаны тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

18.2.Энэ хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

#### 1/1.8 дугаар зүйлийн 6.29, 6.30 дахь заалт:

“6.29.хорих ангийн эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 15.27 дугаар зүйлийн 3.11, 3.12, 3.13 дахь заалт, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан зөрчил;

6.30.Авлигатай тэмцэх байгууллагын эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.30 дугаар зүйлд заасан зөрчил.”

#### 2/1.9 дүгээр зүйлийн 1.6, 1.7 дахь заалт:



“1.6.Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт зааснаас бусад зөрчил үйлдсэн этгээд нь арван зургаан насанд хүрээгүй бол;

1.7.Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 9 дэх хэсэгт заасан зөрчил үйлдсэн этгээд нь арван дөрвөн насанд хүрээгүй бол.”

### **3/1.12 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Прокурор энэ зүйлийн 8.1, 8.2 дахь заалтад заасан шийдвэр гаргахдаа гомдол гаргагчийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах арга хэмжээг даруй авч болно.”

### **4/1.14 дүгээр зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Прокурор, шүүх энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан гомдлыг хүлээн авснаас хойш ажлын 2 өдөрт багтаан шийдвэрлэнэ.”

### **5/3.8 дугаар зүйл:**

#### **“3.8 дугаар зүйл.Шинжээч:**

1.Шинжээчийг эрх бүхий албан тушаалтан, эсхүл эрх бүхий албан тушаалтны шинжилгээ хийлгэх хүсэлтийн дагуу шинжилгээний байгууллагаас томилно.

#### **2.Шинжээч дараах эрхтэй:**

2.1.зөрчлийн хавтаст хэргийн материалаас шинжилгээ хийх зүйлд холбогдох хэсэгтэй нь танилцах;

2.2.эрх бүхий албан тушаалтны зөвшөөрснөөр зөрчил шалгах ажиллагаанд оролцох, шинжилгээ хийхтэй холбоотой асуудлаар оролцогчид асуулт тавих, зөрчил шалгах ажиллагааны тэмдэглэлд нэмэлт, өөрчлөлт оруулах санал гаргах;

2.3.дүгнэлт гаргахад хэрэгцээтэй нэмэлт баримт ирүүлэх талаар шүүх, эрх бүхий албан тушаалтанд хандаж хүсэлт гаргах;

2.4.шинжээчид тавьсан асуулт нь түүний тусгай мэдлэгийн хүрээнээс хэтэрсэн, эсхүл тусгай мэдлэгт хамаарахгүй, эсхүл шинжилгээ хийх баримт сэлтэд холбогдох хүн, байгууллагатай ашиг сонирхлын зөрчил үүсэхээр бол шинжилгээ хийж, дүгнэлт гаргахаас татгалзах;



2.5. шинжилгээний байгууллагаас гадуур шинжээчээр томилогдсон тохиолдолд шинжилгээний зардал, ажлын хөлсийг гаргуулан авах;

2.6. аюулгүй байдлаа хамгаалуулах хүсэлтийг холбогдох эрх бүхий байгууллага, албан тушаалтанд гаргах.

3. Шинжээч дараах үүрэгтэй:

3.1. эрх бүхий албан тушаалтны тавьсан асуултын дагуу тусгай мэдлэг, мэргэжлийн хүрээнд шинжилгээг тал бүрээс нь бүрэн бодитой хийж, тогтоосон хугацаанд шинжлэх ухааны үндэслэл бүхий дүгнэлтийг бичгээр гаргах;

3.2. гаргасан дүгнэлттэй холбоотой асуудлаар мэдүүлэг өгөх.

4. Шинжээч тавьсан асуултын заримыг санаатайгаар хариулахгүй орхисон, эсхүл тогтоосон хугацааг хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хэтрүүлсэн, эсхүл худал дүгнэлт гаргасан бол хуульд заасан хариуцлага хүлээнэ.

5. Шинжээчийн үүргийг багаар гүйцэтгэж болно.”

#### **6/4.2 дугаар зүйлийн 4-8 дахь хэсэг:**

“4. Хойшлуулшгүй тохиолдолд энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан ажиллагааг прокурорын зөвшөөрөлгүй явуулсан бол ажиллагаа дууссанаас хойш даруй зөвшөөрөлгүй явуулах болсон үндэслэлийн тайлбарыг бичгээр гаргаж, нотлох баримтын хамт прокурорт хүргүүлнэ.

5. Прокурор энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан тайлбар, нотлох баримтыг хүлээн авснаас хойш 24 цагийн дотор зөрчил шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох эсэхийг шийдвэрлэнэ.

6. Прокурор зөрчил шалгах ажиллагааг даруй явуулахгүй бол нотлох баримт гэмтэх, устах, зөөвөрлөх, нуун далдлах бодит эрсдэл байсан эсэхийг хянан шийдвэрлэхийн тулд тухайн ажиллагаанд оролцсон хүнийг дуудаж мэдүүлэг авч, шаардлагатай нэмэлт материалыг эрх бүхий албан тушаалтнаас гаргуулан авч болно.

7. Прокурор эрх бүхий албан тушаалтнаас ирүүлсэн тайлбар, нотлох баримттай танилцсаны дараа дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

7.1. зөрчил шалгах ажиллагааг хүчинтэйд тооцох;

7.2. зөрчил шалгах ажиллагаа, нотлох баримтыг хүчингүй болгох.





8.Энэ зүйлийн 7.2 дахь заалтад заасан прокурорын шийдвэрт хураан авсан эд зүйл, баримт бичиг, битүүмжилсэн эд хөрөнгийг эзэмшигчид нь эргүүлэн олгохыг даалгана.”

#### **7/4.5 дугаар зүйлийн 3-8 дахь хэсэг:**

“3.Эрх бүхий албан тушаалтан шуудан-цахилгаанаар явуулсан зүйлийг шуудан-цахилгаан харилцааны байгууллагад байх үед нь прокурорын зөвшөөрлөөр хураан авах, эсхүл үзлэг хийж болно.

4.Зарим онцлох эд зүйл, үнэт эдлэл, түүх, соёлын дурсгалт зүйл, тэсэрч дэлбэрэх, хордуулах бодисыг хураан авах ажиллагаанд мэргэжилтнийг оролцуулж, эсхүл мэргэжлийн байгууллагад хандан гүйцэтгүүлж болно.

5.Баримт бичгийг эхээр нь, шаардлагатай бол хууль ёсны эзэмшигчид эхийг нь буцаан олгож, хуулбарыг зөрчлийн хэрэгт хавсарган тэмдэглэлд тусгана.

6.Хураан авсан эд зүйл, баримт бичгийн жагсаалт, тэмдэглэлийг эд зүйл, баримт бичгээ хураалгасан болон тухайн ажиллагаанд байлцсан хүнээр гарын үсэг зуруулж, хувийг эд зүйлийн эзэмшигч, эсхүл түүний хууль ёсны төлөөлөгч, өмгөөлөгчид даруй гардуулна.

7.Эд зүйл, баримт бичиг хураан авах ажиллагааны үед үзлэг хийхдээ энэ хуулийн 4.3 дугаар зүйлд заасан журмыг баримтална.

8.Хэрэгт ач холбогдолтой цахим баримтыг хуулбарлан авах, эсхүл түүнийг устгах, нэвтрэх боломжийг хязгаарлах боломжгүй бол цахим төхөөрөмжийг хураан авч болно.”

#### **8/4.11 дүгээр зүйлийн 2.4 дэх заалт:**

“2.4.хүний биед гэмтэл учирсан эсэхийг тогтоох шаардлагатай бол.”

#### **9/4.11 дүгээр зүйлийн 9-16 дахь хэсэг:**

“9.Шинжилгээний объектыг хүргэх, тээвэрлэх боломжгүй тохиолдолд шинжээчийг шинжилгээний объект байгаа газарт чөлөөтэй нэвтрүүлэх, шинжилгээ хийх нөхцөлөөр хангах үүргийг шинжилгээ хийлгэх хүсэлт гаргасан, шинжээч томилсон эрх бүхий байгууллага, албан тушаалтан хүлээнэ.

10.Энэ зүйлийн 8 дахь хэсэгт заасан шийдвэрт шинжилгээ хийлгэх үндэслэл, шинжилгээний байгууллагын болон шинжээчийн нэр, шинжээчид тавих асуулт, шинжилгээ хийж дүгнэлт гаргах хугацаа, шинжээчийн мэдэлд шилжүүлэн өгсөн шинжилгээний объектын талаарх мэдээллийг тусгана.

11.Шинжилгээний байгууллага нь шинжилгээ хийлгэх тухай шийдвэрийг хүлээн авмагц шинжээч, эсхүл шинжээчдийн багт шинжилгээ хийлгэхээр даалгана.

12.Шинжээчдийн багийн бүрэлдэхүүнд тухайн байгууллагад ажилладаггүй тусгай мэдлэг эзэмшсэн хүнийг шинжээчээр оролцуулж болно.

13.Энэ зүйлийн 12 дахь хэсэгт заасан тохиолдолд тухайн хүнийг шинжээчээр оролцуулах тухай шинжилгээний байгууллага нь шинжээч томилсон эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэнэ.

14.Эрх бүхий албан тушаалтан холбогдогчийг донтох сэтгэцийн эмгэгтэй эсэхийг тогтоолгох шаардлагатай гэж үзвэл шинжилгээнд хамруулах тухай шийдвэрийг эмнэлгийн байгууллагад хүргүүлнэ.

15.Донтох сэтгэцийн эмгэгтэй эсэхийг тогтоолгох шаардлагатай холбогдогч өөртөө, эсхүл бусдад аюул учруулж болзошгүй бол эмнэлгийн байгууллагад албадан хүргэж болно.

16.Эмнэлгийн байгууллагад албадан хүргэх ажиллагааг тухайн шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан цагдаагийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ.”

#### **10/4.12 дугаар зүйлийн 2-17 дахь хэсэг:**

“2.Эрх бүхий албан тушаалтны энэ хуулийн 6.10 дугаар зүйлд заасны дагуу гаргасан шийдвэр, зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэр хуулийн хүчин төгөлдөр болох хүртэл, эсхүл зөрчлийн хэргийг хэрэгсэхгүй болгосон шийдвэрт гомдол гаргах, давж заалдах хугацаа дуустал хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг зохих журмын дагуу хадгалж, энэ тухай баримтыг зөрчлийн хэрэгт хавсаргана.

3.Хураан авсан үндэсний болон гадаад валютыг тусгай дансанд байршуулна.

4.Хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах талаар гаргасан оролцогчийн хүсэлтийг үндэслэн, тэдгээрийг хадгалах асуудлыг эрх бүхий албан тушаалтан, прокурор, шүүхийн шийдвэрт тусгайлан зааж болно.



5.Тусгай хадгалалт, хамгаалалт шаардлагатай хөрөнгө, орлого, эд зүйл, шинжилгээний объектыг шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтан, шинжилгээний байгууллагын шинжээчийн саналаар тухайн байгууллагаас өөр байгууллагад хадгалуулж болно.

6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт заасны дагуу хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйлийг хадгалах, хамгаалах, хяналт тавих үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтан тэдгээрийн бүрэн бүтэн байдлыг хариуцна.

7.Зөрчлийн хэргийг харьяаллын дагуу, эсхүл шүүхэд шилжүүлэхдээ хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн хамт хүргүүлнэ.

8.Зөрчлийн хэргийг шүүхэд шилжүүлэхэд овор хэмжээний хувьд болон бусад шалтгаанаар хөрөнгө, орлого, эд зүйлийн хамт хүргүүлэх боломжгүй бол түүнийг шүүхийн шийдвэр гартал зохих журмын дагуу хадгалж, энэ тухай баримтыг зөрчлийн хэрэгт хавсаргана.

9.Эрх бүхий албан тушаалтны хураан авсан хөрөнгө, орлого, эд зүйл, шинжилгээний объект нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх бодит үндэслэл бий болсон, эсхүл түргэн муудах, гэмтэх, устах, эсхүл зөрчлийг шийдвэрлэгдэх хүртэл чанар нь муудах хөрөнгө, орлого, эд зүйлийг эзэмшигчид нь буцаан өгөх боломжгүй тохиолдолд шүүхэд хүсэлт гаргаж шийдвэрлүүлнэ.

10.Эрх бүхий албан тушаалтны хүсэлтийг хүлээн авсан шүүх ажлын 2 өдрийн дотор дараах шийдвэрийн аль нэгийг гаргана.

10.1.хэрэгцээний дагуу зохих байгууллагад шилжүүлэх;

10.2.хадгалуулахаар зохих байгууллагад шилжүүлэх;

10.3.худалдан борлуулж орлогыг тусгай дансанд хадгалах;

10.4.устгуулахаар зохих байгууллагад шилжүүлэх.

11.Эрх бүхий албан тушаалтны энэ хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гаргасан шийдвэр, эсхүл зөрчлийн хэргийг хянан шийдвэрлэсэн шүүхийн шийдвэрт хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийг буцаан олгохоор заасан боловч энэ зүйлийн 10.1, 10.3, 10.4 дэх заалтад заасны дагуу тухайн хөрөнгө, орлого, эд зүйлийг шилжүүлсэн, худалдан борлуулсан, устгасан тохиолдолд эзэмшигчид нь адил төрөл, чанарын эд зүйлийг олгох, эсхүл үнийг төлнө.

12.Эрх бүхий байгууллага нь энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан ажиллагааны тэмдэглэл, устгасан, шилжүүлсэн, худалдан борлуулсан хөрөнгө, орлого, эд зүйлийн жагсаалтыг зөрчлийн хэрэгт хавсаргана.

13.Зөрчлийн хэргийн материал, хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийг хүлээн авах, хадгалах, шилжүүлэх болон энэ зүйлийн 10 дахь хэсэгт заасан ажиллагааны журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, Улсын ерөнхий прокурор хамтран батална.

14.Шүүх энэ хуулийн 1.8 дугаар зүйлийн 7, 8 дахь хэсэгт заасан зөрчлийн хэргийн улмаас хураан авсан, битүүмжилсэн эд зүйлийн талаар энэ зүйлийн 15 дахь заалтад заасан шийдвэрийг гаргана.

15.Эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 6.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэрийг гаргахдаа зөрчил шалгах ажиллагааны журмын дагуу хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн талаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 15.1.эзэмшигчид нь буцаан олгох;
- 15.2.устгах;
- 15.3.улсын орлого болгох;
- 15.4.зөрчлийн хэрэгт хадгалах.

16.Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийг буцаан олгох нь хүний эрүүл мэнд, байгаль орчин, мал амьтанд хортой нөлөө үзүүлэх, нийтийн аюулгүй байдалд сөргөөр нөлөөлөх бодит үндэслэлтэй, эзэмшигч, өмчлөгч нь тодорхойгүй, эсхүл хуулиар хориглосон, нийтээр хүлээн зөвшөөрсөн зан суртахууны хэм хэмжээнд харшлахаар бол эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 15.2, 15.3 дахь заалтад заасан шийдвэрийг гаргана.

17.Хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийг зөрчлийн хэрэгт эд мөрийн баримтаар хадгалах шаардлагатай бол энэ зүйлийн 15.4 дэх заалтад заасан шийдвэрийг гаргана.”

#### **11/4.13 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Зөрчил шалгах ажиллагаанд оролцсон хүн хүндэтгэн үзэх шалтгааны улмаас тэмдэглэлд гарын үсэг зурах боломжгүй бол энэ тухай эрх бүхий албан тушаалтан тайлбар бичиж тэмдэглэлд хавсаргана.”

#### **12/4.16 дугаар зүйл:**

##### **“4.16 дугаар зүйл.Дуудан ирүүлэх**

1.Эрх бүхий албан тушаалтан мэдүүлэг авах, шийдвэр танилцуулах, хэрэг бүртгэлтийн ажиллагаанд оролцуулахаар зөрчлийн холбогдогчийг дуудан ирүүлж болно.



2.Холбогдогчийг дуудах хуудсаар, эсхүл харилцаа холбооны хэрэгсэл ашиглан дуудаж болно.

3.Энэ хуулийн 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн холбогдогч оргон зайлсан бол түүний хаана байгааг олж тогтоох зорилгоор цагдаагийн байгууллагаас эрэн сурвалжлах ажиллагааг явуулж болно.

4.Эрэн сурвалжлах ажиллагааны зардлыг энэ хуулийн 1.11 дүгээр зүйлд заасан журмаар тооцож, холбогдогчоор нөхөн төлүүлнэ.

5.Энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн холбогдогч дуудсан цагт ирээгүй бол түүнийг албадан ирүүлнэ.

6.Холбогдогчийг албадан ирүүлэх журмыг Улсын Ерөнхий прокурор, хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.”

#### **13/4.17 дугаар зүйл:**

##### **“4.17 дугаар зүйл.Зөрчлийн хэргийг нэгтгэх, тусгаарлах**

1.Нэг, эсхүл хэд хэдэн зөрчлийг хэд хэдэн холбогдогч хамтран үйлдсэн, эсхүл нэг холбогдогч хэд хэдэн зөрчлийг үйлдсэн бол зөрчлийн хэргийг нэгтгэж шалгах ажиллагааг явуулж болно.

2.Зөрчлийн хэргийг тал бүрээс нь бүрэн бодитой шалган шийдвэрлэхэд саад болохгүй бол зарим холбогдогчид холбогдох зөрчлийн хэргийг тусгаарлаж болно.

3.Зөрчлийн хэргийн нэгтгэх, эсхүл тусгаарлах тухай саналыг эрх бүхий албан тушаалтан энэ хуулийн 4.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу прокурорт гаргана.

4.Прокурор энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан саналыг хүлээн авснаас хойш ажлын 3 өдөрт багтаан дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

4.1.зөрчлийн хэргийг тусгаарлах, эсхүл нэгтгэх;

4.2.зөрчлийн хэргийг тусгаарлах, эсхүл нэгтгэхээс

татгалзах.

5.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 4 дэх хэсэгт заасан прокурорын шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 2.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан журмаар гомдол гаргана.

6.Зөрчлийн хэргийг нэгтгэн шалгах ажиллагааг явуулсан боловч зарим зөрчлийн хэрэг нь нотлогдоогүй бол эрх бүхий албан тушаалтан зөрчлийн хэргийг тусгаарлан, хэрэгсэхгүй болгоно.”

**14/6.5 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Прокурор эрх бүхий албан тушаалтны зөрчлийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авахаас татгалзсан шийдвэрийг хянаад дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

3.1.шийдвэрийг хэвээр үлдээх;

3.2.шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл хүчингүй болгож, даалгавар өгөх;

3.3.шийдвэрийг хүчингүй болгож, зөрчлийн болон эрүүгийн хэрэг бүртгэлтийн хэрэг нээх, эрүүгийн хэрэг үүсгэж яллагдагчаар татах.”

**15/6.6 дугаар зүйлийн 6-9 дэх хэсэг:**

“6.Эрх бүхий албан тушаалтан зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэхдээ энэ хуулийн 7.4 дүгээр зүйлд заасны дагуу зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээг авч болно.

7.Прокурор эрх бүхий албан тушаалтны зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэн шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасан харьяаллын дагуу дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлнэ.

8.Оролцогч зөрчлийг хялбаршуулсан журмаар шалган шийдвэрлэсэн эрх бүхий албан тушаалтны шийтгэл оногдуулсан, шийтгэлээс чөлөөлсөн шийдвэрт энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргана.

9.Эрх бүхий албан тушаалтны хялбаршуулсан журмаар зөрчлийг шийдвэрлэсэн шийдвэрийг биелүүлэх ажиллагаанд энэ хуулийн 7.5 дугаар зүйлд заасан журмыг баримтална.”

**16/6.8 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзсан, эрүүгийн хэргийг хэрэгсэхгүй болгосон үйлдэл, эс үйлдэлд зөрчлийн хэрэг нээх тухай прокурорын шийдвэрийг эрх бүхий байгууллага хүлээн авсан өдрөөс эхлэн зөрчлийн хэрэг бүртгэлтийн хугацааг тоолно.”

**17/6.9 дүгээр зүйлийн 5, 6 дахь хэсэг:**

“5.Эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 5.4 дүгээр зүйлийн 4 дэх хэсэг, 6.20, 6.26 дугаар зүйлд заасан зөрчлийн хохирогч, гэрч, тэдгээрт тусламж, үйлчилгээ үзүүлсэн хүний аюулгүй байдлыг хангах зорилгоор зөрчлийн хэргийг холбогдогч, түүний өмгөөлөгч, төлөөлөгчид



танилцуулахдаа хохирогч, гэрчийн мэдүүлэг болон биеийн байцаалтыг нууцлах арга хэмжээг авна.

6.Шаардлагатай бол мэдээлэл нууцлах арга хэмжээг энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаас бусад зөрчлийн гэрч, хохирогчийг хамгаалах зорилгоор хэрэглэж болно.”

#### **18/6.12 дугаар зүйл:**

##### **“6.12 дугаар зүйл.Шийтгэлээс чөлөөлөх**

1.Эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйл, 3.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр зөрчил үйлдсэн хүнийг шийтгэлээс чөлөөлөх тухай шийдвэр гаргаж, прокурорт даруй мэдэгдэнэ.

2.Эрх бүхий албан тушаалтан энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан шийдвэр гаргахдаа дараах нөхцөл байдлыг тогтоосон байна:

2.1.тухайн хүнийг зөрчил үйлдсэнийг нотлох баримт бүрдсэн эсэх;

2.2.Зөрчлийн тухай хуулийн 2.3 дугаар зүйлд заасан үндэслэл нотлох баримтаар тогтоогдсон эсэх;

2.3.Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан үндэслэлээр шийтгэлээс чөлөөлж, албадлагын арга хэмжээ хэрэглэх боломжтой эсэх;

2.4.эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх шаардлагатай эсэх;

2.5.зөрчлийн үр дагаврыг арилгах арга хэмжээ авах шаардлагатай эсэх.

3.Эрх бүхий албан тушаалтан зөрчил үйлдсэн хүнд эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ хэрэглэх үндэслэлтэй гэж үзвэл албадлагын арга хэмжээ авахуулах тухай хүсэлтийг энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан журмын дагуу шүүхэд гаргана.

4.Шүүх энэ зүйлийн 3 дахь хэсэгт заасан хүсэлтийг энэ хуулийн 7.3 дугаар зүйлийн 6, 7 дахь хэсэгт заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

5.Эрх бүхий албан тушаалтан Зөрчлийн тухай хуулийн 3.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу арван найман насанд хүрээгүй хүнийг шийтгэлээс чөлөөлөхдөө түүний хувийн байдалтай холбоотой дараах мэдээллийг тогтоосон байна:

5.1.төрсөн он, сар, өдөр, нас;  
5.2.амьдралын нөхцөл байдал ба хүмүүжилтэй холбоотой мэдээлэл;

5.3.зөрчил үйлдэхэд нөлөөлсөн шалтгаан, нөхцөл;  
5.4.зөрчил хамтран үйлдэгч байсан эсэх;  
5.5.өөрийнхөө үйлдлийн холбогдлыг бүрэн ойлгож байгаа эсэхэд эргэлзээ төрвөл шинжээч томилж, дүгнэлт гаргуулах.

6.Холбогдогчийн насыг хуулийн дагуу авсан иргэний бүртгэлийн бичиг баримтаар тодорхойлно.

7.Холбогдогчийн насыг тогтоох зорилгоор дараах тохиолдолд шинжээч томилно:

7.1.энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан бичиг баримт нь хуурамч гэж үзэх үндэслэл байвал;

7.2.энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан бичиг баримт байхгүй бол;

7.3.өөр улсад бүртгэлтэй, энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан бичиг баримтыг олж авах боломжгүй бол.

8.Арван найман насанд хүрээгүй холбогдогчийг шийтгэлээс чөлөөлөхөд түүний зан байдал, араншин, зөрчил үйлдэх үедээ ямар нөхцөл байдалд байсан, зөрчил үйлдэхийн өмнө болон зөрчил үйлдсэний дараа биеэ хэрхэн авч явж байсан зэргийг харгалзан үзэж болно.

9.Эрх бүхий албан тушаалтан шийтгэлээс чөлөөлөх тухай шийдвэрийн хувийг зөрчил үйлдсэн хүнд шийдвэр гарснаас хойш ажлын 3 өдрийн дотор биечлэн танилцуулах, эсхүл харилцаа холбооны хэрэгсэл ашиглан хүргүүлнэ.

10.Төрийн албан хаагчийн хуулиар хүлээсэн албаны чиг үүрэгтэй холбоотой хэрэгжүүлсэн үйлдэл, эс үйлдэхүй нь зөрчлийн шинжтэй бол түүнд холбогдох хариуцлагыг хүлээлгэх талаар харьяалах байгууллагын удирдлагад албан бичгээр, гэмт хэргийн шинжтэй бол энэ хуулийн 4.1 дүгээр зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу прокурорт даруй мэдэгдэнэ.

11.Эрх бүхий албан тушаалтны шийтгэлээс чөлөөлөх тухай шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх үндэслэлтэй гэж үзвэл прокурор дүгнэлт бичиж шүүхэд хүргүүлнэ.

12.Оролцогч эрх бүхий албан тушаалтны шийтгэлээс чөлөөлөх тухай шийдвэрийг эс зөвшөөрвөл энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасны дагуу харьяалах шүүхэд гомдол гаргана.”



**19/7.3 дугаар зүйлийн 8-13 дахь хэсэг:**

“8.Албадан эмчилгээнд хамруулах хугацааг Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд заасны дагуу тухайн этгээдийг албадан эмчлэх байгууллага тогтооно.

9.Шүүх зөрчил үйлдсэн хүнд баривчлах шийтгэлээс гадна албадан эмчлэх албадлагын арга хэмжээ хэрэглэхээр шийдвэрлэсэн бол тухайн этгээд баривчлах шийтгэлийг эдэлж дууссаны дараа түүнийг албадан эмчилгээнд хамруулна.

10.Албадан эмчлэх тухай шүүхийн шийдвэрийг Согтуурах, мансуурах донтой хүнийг захиргааны журмаар албадан эмчлэх тухай хуульд заасан журмаар гүйцэтгэнэ.

11.Албадан эмчилгээнд хамруулах шаардлагатай холбогдогч нь өөртөө, эсхүл бусдад аюул учруулах, эсхүл оргон зайлж болзошгүй бол албадан эмчлэх тухай шүүхийн шийдвэр гарах хүртэл тухайн хүнийг 48 цаг хүртэл хугацаагаар саатуулж болно.

12.Шүүхийн шийдвэр гарсны дараа албадан эмчлэх газарт хүргэх ажиллагааг шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага гүйцэтгэнэ.

13.Энэ зүйлийн 9 дэх хэсэгт заасан тохиолдолд баривчлах шийтгэлийг гүйцэтгэсэн байгууллага тухайн этгээдийг албадан эмчлэх байгууллагад даруй хүргэнэ.”

**20/8.2 дугаар зүйлийн 9-13 дахь хэсэг:**

“9.Шүүх зөрчлийн хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхэд Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.3, 38.4, 39.1, 39.2, 39.3, 39.4, 39.10, 39.11, 39.12 дугаар зүйл, 39.9 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь заалт, 2 дахь хэсэгт заасан журмыг баримтална.

10.Дараах үндэслэлийн аль нэг нь байвал давж заалдах шатны шүүх анхан шатны шүүхийн шийдвэрийг хүчингүй болгох, эсхүл өөрчилнө:

10.1.шүүхийн шийдвэрт заасан үндэслэл нь хэргийн бодит байдалтай нийцээгүй;

10.2.Зөрчлийн тухай хуулийг буруу хэрэглэсэн;

10.3.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн.

11.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 39.6 дугаар зүйлд заасан нөхцөл байдлын аль нэг нь байгаа бол анхан шатны шүүхийн шийдвэрт заасан дүгнэлт хэргийн бодит байдалд нийцээгүй гэж үзнэ.

12.Дараах нөхцөлийн аль нэг тогтоогдвол шүүх Зөрчлийн тухай хуулийг буруу хэрэглэсэн гэж үзнэ:

12.1.шүүх хэрэглэвэл зохих хуулийг хэрэглээгүй;

12.2.хэрэглэх ёсгүй хуулийг хэрэглэсэн;

12.3.хуулийн зүйл, хэсэг, заалтыг буруу тайлбарлаж хэрэглэсэн.

13.Дараах нөхцөл байдлын аль нэг нь тогтоогдвол анхан шатны шүүх шийдвэр гаргахдаа Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийг ноцтой зөрчсөн гэж үзнэ:

13.1.шүүх шийдвэр гаргахдаа энэ хуулийн 4.15 дугаар зүйлийн 3, 5 дахь хэсэгт заасан нотлох баримтыг ашигласан;

13.2.шүүхийн шийдвэр нь Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 36.2, 36.6, 36.7, 36.8, 36.9 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангаагүй;

13.3.зөрчлийн хэрэгт шүүх хуралдааны тэмдэглэл, түүнд хавсаргасан нотлох баримт байгаагүй;

13.4.шүүх хуралдаанд уншиж сонгосон шийдвэрийн тогтоох хэсэг гардуулсан шийдвэрийн тогтоох хэсгээс зөрүүтэй бол;

13.5.анхан шатны шүүх хуралдааны тэмдэглэл, дуу-дүрсний бичлэг зөрүүтэй бол;

13.6.илт үндэслэлгүйгээр хэргийг хэрэгсэхгүй болгосон бол.”

### **21/9.2 дугаар зүйлийн 14 дэх хэсэг:**

“14.Шүүх энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан зөрчлийн хэргийг давж заалдах шатны журмаар хянан шийдвэрлэхэд энэ хуулийн 8.2 дугаар зүйлийн 10, 11, 12, 13 дугаар зүйл, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.3, 38.4, 39.1, 39.2, 39.3, 39.4, 39.10, 39.11, 39.12 дугаар зүйл, 39.9 дүгээр зүйлийн 1.1, 1.2 дахь заалт, 2 дахь хэсэгт заасан журмыг тус тус баримтална.”

**2 дугаар зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.7 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийн “төрийн” гэсний дараа “болон албаны” гэж, 1.8 дугаар зүйлийн 6.3 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний



дараа “14.12 дугаар зүйл,” гэж, мөн зүйлийн 6.13 дахь заалтын “Зөрчлийн тухай хуулийн” гэсний дараа “11.7 дугаар зүйлийн 3 дахь хэсэг,” гэж, мөн зүйлийн 7 дахь хэсгийн “8.6” гэсний өмнө “6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.26 дугаар зүйл,” гэж, 2.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсгийн “шийтгэл оногдуулсан” гэсний дараа “, шийтгэлээс чөлөөлсөн” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “6.26” гэсний дараа “,6.29, 6.30” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “6.27” гэсний дараа “, 6.28” гэж, 2.2 дугаар зүйлийн 1.4 дэх заалтын “бусад” гэсний өмнө “хуульд заасан” гэж, мөн зүйлийн 3 дахь хэсгийн “хянан” гэсний дараа “, гомдолд дурдсан шийдвэрийг хүчингүй болгох, өөрчлөх, эсхүл гомдлыг хүлээн авахаас татгалзан” гэж, 4.11 дүгээр зүйлийн 4 дэх хэсгийн “шинжилгээ хийж” гэсний дараа “, магадалгаа гаргаж” гэж, 6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “зөрчлийг” гэсний дараа “газар дээр нь, эсхүл” гэж, 7.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн, 7.5 дугаар зүйлийн 8 дахь хэсгийн “харьяалах” гэсний өмнө “энэ хуулийн 7.6 дугаар зүйлд заасан” гэж, 7.6 дугаар зүйлийн гарчгийн “Шийтгэл оногдуулсан” гэсний дараа “, шийтгэлээс чөлөөлсөн” гэж, мөн зүйлийн 1, 2 дахь хэсгийн “шийтгэл оногдуулсан” гэсний дараа “, шийтгэлээс чөлөөлсөн” гэж, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “6.26” гэсний дараа “,6.29, 6.30” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн “6.27” гэсний дараа “, 6.28” гэж , 9.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “8.6” гэсний өмнө “6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсэг, 6.26 дугаар зүйл” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн дараах хэсэг, заалтыг доор дурдсан агуулгаар өөрчлөн найруулсугай:

#### **1/1.8 дугаар зүйлийн 6.6 дахь заалт:**

“6.6.олон нийтийн цагдаа Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 5.5 дугаар зүйл, 6.1 дүгээр зүйлийн 7.2 дахь заалт, 6.3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 13 дахь хэсэг, 14.7 дугаар зүйлийн 20, 21, 22, 23, 24, 25, 26, 27, 28, 29, 33, 34, 35, 36, 37, 38, 39, 40, 41, 44, 46, 47, 50, 53 дахь хэсэгт заасан зөрчил;”

#### **2/1.8 дугаар зүйлийн 6.8 дахь заалт:**

“6.8.цагдаагийн байгууллагын эрх бүхий алба хаагч Зөрчлийн тухай хуулийн 5.1 дүгээр зүйлийн 1, 2 дахь хэсэг, 5.3 дугаар зүйл, 5.4 дүгээр зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг, 5.5, 5.6, 5.7 дугаар зүйл, 5.8 дугаар зүйлийн 1, 2, 3, 4, 5 дахь хэсэг, 5.9 дүгээр зүйл, 5.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.11 дүгээр зүйлийн 1.5 дахь заалт, 5.12 дугаар зүйлийн 1, 4 дэх хэсэг, 2.1 дэх заалт, 3 дахь хэсэг, 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.16, 5.18, 5.19 дүгээр зүйл, 6.3 дугаар зүйлийн 1, 2, 4 дэх хэсэг, 6.5 дугаар зүйлийн 1, 4, 5, 11, 12, 13, 15, 16 дахь хэсэг, 6.18 дугаар зүйлийн 4, 7 дахь хэсэг, 6.20 дугаар зүйлийн 7 дахь хэсэг, 6.22, 6.24 дүгээр зүйл, 7.15 дугаар зүйлийн 8 дахь хэсэг, 8.8, 8.9 дүгээр зүйл, 10.4, 10.8, 10.26, 10.28 дугаар зүйл, 11.15 дугаар

зүйлийн 7 дахь хэсэг, 13.5, 14.4, 14.5 дугаар зүйл, 14.6 дугаар зүйлийн 5, 6, 7, 9 дэх хэсэг, 14.7, 15.1 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.6, 15.7, 15.8, 15.9, 15.10, 15.11, 15.18 дугаар зүйл, 15.20 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 15.21 дүгээр зүйл, 15.22 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 15.24 дүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасан зөрчил;”

### **3/1.8 дугаар зүйлийн 6.10, 6.11 дэх заалт:**

“6.10.мэргэжлийн хяналтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.11, 5.12 дугаар зүйл, 5.13 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 5.15 дугаар зүйл, 6.26 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 6.1, 6.2, 6.3, 6.4, 6.5, 6.6, 6.7, 6.8, 6.9, 6.10, 6.11, 6.12, 6.13, 6.14, 6.15, 6.16, 6.17 дугаар зүйл, 6.18 дугаар зүйлийн 5, 6 дахь хэсэг, 6.19, 6.20 дугаар зүйлийн 1.2, 1.3 дахь заалт, 6.23, 6.24, 6.25, 7.1, 7.2, 7.3, 7.4, 7.6, 7.7, 7.8, 7.9, 7.10, 7.11, 7.12, 7.13, 7.14, 7.15 дугаар зүйл, 7.16 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 7.17, 8.1, 8.2, 9.1, 9.2, 9.3 дугаар зүйл, 9.4 дүгээр зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг, 9.5, 9.6, 9.7, 9.9 дүгээр зүйл, 9.10 дугаар зүйлийн 2.2, 2.3 дахь заалт, 3 дахь хэсэг, 9.11, 10.2, 10.3, 10.4, 10.12, 10.13, 10.14, 10.15, 10.16, 10.17, 10.19, 10.22, 10.24, 10.25, 10.27, 11.2, 11.22 дугаар зүйл, 11.25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 12.1, 12.2, 12.3, 12.4, 12.5, 12.6, 12.7, 12.8, 12.9, 12.10, 12.11, 12.12, 13.1, 13.2, 13.4, 13.5, 13.7, 13.9, 14.1, 14.2, 14.3, 14.4, 14.5, 14.6, 14.11 дүгээр зүйл, 15.2 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 15.22 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 16.4 дүгээр зүйлд заасан зөрчил;

6.11.гаалийн улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 5.6 дугаар зүйлийн 7, 9, 10 дахь хэсэг, 5.12 дугаар зүйлийн 4 дэх хэсэг, 6.1 дүгээр зүйлийн 4.2 дахь заалт, 6.4 дүгээр зүйлийн 1.1, 2.8 дахь заалт, 6.5 дугаар зүйлийн 9 дэх хэсэг, 7.2 дахь заалт, 6.18 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 7.3 дугаар зүйл, 8.3 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 9.7 дугаар зүйлийн 1.4 дэх заалт, 11.21 дүгээр зүйл, 11.24 дүгээр зүйлийн 1.1, 1.4, 1.5, 1.6 дахь заалт, 11.29 дүгээр зүйлийн 22 дахь хэсэг, 15.2 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 16.1 дүгээр зүйлийн 2, 3 дахь хэсэг, 16.4 дүгээр зүйлд заасан зөрчил;”

### **4/1.8 дугаар зүйлийн 9 дэх хэсэг:**

“9.Энэ зүйлийн 7 дахь хэсэгт заасан Зөрчлийн тухай хуулийн 6.20 дугаар зүйлийн 6 дахь хэсгийн зөрчлийн хэрэг бүртгэлтийг ахлах шийдвэр гүйцэтгэгч, энэ хэсэгт заасан бусад зөрчлийн хэрэг бүртгэлтийг цагдаагийн байгууллага гүйцэтгэнэ”.

### **5/1.12 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Оролцогч энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан гомдлыг дараах хугацаанд бичгээр гаргана:



2.1.энэ хуулийн 6.5, 6.11 дүгээр зүйлд заасан шийдвэрт тухайн шийдвэрийг хүлээн авснаас хойш ажлын 5 өдрийн дотор;

2.2.энэ зүйлийн 2.1 дэх заалтад зааснаас бусад шийдвэр, үйл ажиллагааны талаарх гомдлыг зөрчил шалган шийдвэрлэх ажиллагааны аль ч үед.”

#### **6/1.12 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Эрх бүхий албан тушаалтан, эсхүл прокурорын шийдвэр, үйл ажиллагаатай холбоотой гомдлыг энэ зүйлийн 3, 5 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авч хянасан прокурор дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

- 8.1.шийдвэр, үйл ажиллагааг хүчингүй болгох;
- 8.2.шийдвэр, үйл ажиллагааг өөрчлөх;
- 8.3.гомдлыг хүлээн авахаас татгалзах.”

#### **7/1.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:**

“4.Энэ зүйлийн 1 дэх хэсгийн хүсэлтэд заасан асуудлаар оролцогч энэ хуулийн 1.12 дугаар зүйлд заасны дагуу гомдол гаргаж шийдвэрлүүлж байсан нь тухайн хүсэлтийг хүлээн авахаас татгалзах үндэслэл болно.”

#### **8/4.2 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:**

“3.Прокурор энэ зүйлийн 2 дахь хэсэгт заасан саналыг хүлээн авсан даруй зөвшөөрөл олгох эсэх тухай шийдвэр гаргана.”

#### **9/4.5 дугаар зүйлийн 2 дахь хэсэг:**

“2.Эрх бүхий албан тушаалтан хураан авах ажиллагааг эхлэхийн өмнө хураан авах эд зүйл, баримт бичгийг сайн дураар гаргаж өгөх, зааж өгөх боломжийг тухайн хүн, хуулийн этгээдийн төлөөлөгчид олгоно.”

#### **10/4.6 дугаар зүйлийн 5 дахь хэсэг:**

“5.Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 87 дугаар зүйлд заасан хүний зайлшгүй хэрэгцээний эд зүйлийг битүүмжилж болохгүй.”

#### **11/4.10 дугаар зүйлийн 4, 5 дахь хэсэг:**

“4.Шинжилгээнд зориулан авсан хэв загвар, дээжийг хадгалах, шилжүүлэх, устгах, тээвэрлэх журмыг Засгийн газар батална.

5.Хэв загвар, дээж авах ажиллагааг хэрэг бүртгэлтийн ажиллагааны аль ч үед явуулж болно.”

#### **12/4.11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Эрх бүхий албан тушаалтан шинжилгээ хийлгэх шийдвэрээ шинжилгээний байгууллага, шинжээчид шинжилгээний объект, эсхүл түүний дээжийн хамт хүргүүлнэ.”

#### **13/4.12 дугаар зүйлийн 1 дэх хэсэг**

“1.Шүүх, прокурор, эрх бүхий албан тушаалтан хураан авсан, битүүмжилсэн хөрөнгө, орлого, эд зүйлийн хадгалалт, хамгаалалтыг хариуцна.”

#### **14/4.13 дугаар зүйлийн 8 дахь хэсэг:**

“8.Тэмдэглэлд зөрчил шалгах ажиллагаанд ашиглаж байгаа техник хэрэгслийн нэр төрөл, үзүүлэлтийг тэмдэглэж, бичлэг хийсэн цаг, минут, авсан гэрэл зургийн тоог тусгана. Дуу-дүрсний бичлэгт тухайн ажиллагааны зорилго, он, сар, өдөр, байршил, эхэлсэн, дууссан цаг, минутыг тусгана.”

#### **15/7.5 дугаар зүйлийн 6 дахь хэсэг:**

“6.Энэ зүйлийн 5 дахь хэсэгт зааснаар хураан авсан, битүүмжилсэн эд зүйлийн хадгалалт, хамгаалалтыг шийдвэр гаргасан эрх бүхий албан тушаалтан, эрх бүхий байгууллага, хөрөнгийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарласан тухай шийдвэрийг хүлээн авсан байгууллага хариуцна.”

#### **16/8.2 дугаар зүйлийн 7 дахь хэсэг:**

“7.Энэ зүйлийн 6 дахь хэсэгт заасан гомдол, эсэргүүцлийг Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 38.1, 38.2 дугаар зүйлд заасан журмаар гаргана.”

**4 дүгээр зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.2 дахь заалтын “түүний орлогч, туслах” гэснийг “орлогч, туслагч” гэж, мөн зүйлийн 6.9 дэх заалтын “15.27 дугаар зүйлд” гэснийг “15.27 дугаар зүйлийн 1, 2 дахь хэсэг, 3.1, 3.2, 3.3, 3.4, 3.5, 3.6, 3.7, 3.8, 3.9, 3.10, 3.14 дэх заалтад” гэж, мөн зүйлийн 6.2, 6.13 дахь заалтын “15.2 дугаар зүйлийн 1 дэх” гэснийг “15.2 дугаар зүйлийн 2 дахь” гэж, мөн зүйлийн 6.14 дэх заалтын “11.10 дугаар зүйлийн 2.4, 5.4” гэснийг “11.10 дугаар зүйлийн 2.1, 5.4, 12.4” гэж, мөн зүйлийн 6.19 дэх заалтын “11.31 дүгээр зүйлд” гэснийг “11.31, 11.32 дугаар зүйлд” гэж, мөн зүйлийн 6.22 дахь заалтын “11.1,” гэснийг “11.1 дүгээр зүйл, 11.10 дугаар зүйлийн 14 дэх хэсэг, 11.13 дугаар зүйл,” гэж, 6.26 дахь заалтын “6.20 дахь заалтын 1, 2, 3, 4, 5, 7,



8 дахь хэсэг,” гэснийг “6.20 дугаар зүйл,” гэж, 1.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн, 1.13 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “гаргаж болно” гэснийг “гаргах эрхтэй” гэж, 1.15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “талаархи” гэснийг “баримт,” гэж, мөн хэсгийн “баримтыг” гэснийг “материалыг” гэж, 2.2 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 15.6, 15.7 дугаар зүйлд” гэснийг “энэ хуулийн 1.12 дугаар зүйлийн 8, 9 дэх хэсэгт” гэж, 3.4 дүгээр зүйлийн 6 дахь хэсгийн “1.1 дэх заалтад” гэснийг “1 дэх хэсэгт” гэж, 4.2 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн “зөвшөөрлийг прокуророос авахдаа Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 22.2, 22.3 дугаар зүйлд заасан журмыг баримтлана.” гэснийг “саналыг уг ажиллагааг явуулахаас өмнө прокурорт хүргүүлнэ.” гэж, 4.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “бүртгэл” гэснийг “бүртгэлийн шилжилт хөдөлгөөнийг хязгаарлах” гэж, мөн хэсгийн “хязгаарлахыг” гэснийг “хязгаарлах, тусгаарлахыг” гэж, 4.13 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “1.1 дэх заалтад” гэснийг “1 дэх хэсэгт” гэж, 5.3 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “даруй” гэснийг “энэ хуулийн 4.2 дугаар зүйлд заасан журмын дагуу” гэж, 6.1 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн “3” гэснийг “5” гэж, 6.7 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “6.6 дугаар зүйлд” гэснийг “6.6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт” гэж, “7.2 дугаар зүйлийн 7 дахь хэсгийн “хуудасны маягтыг” гэснийг “болон шийтгэлээс чөлөөлөх хуудасны маягт, хэрэглэх журмыг” гэж, 7.3 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 21.2, 24.4 дүгээр зүйлд” гэснийг “энэ хуулийн 4.5, 4.6 дугаар зүйлд” гэж, 9.2 дугаар зүйлийн 3 дахь хэсгийн “1 дэх хэсэгт” гэснийг “1.1, 1.3 дахь заалтад” гэж, мөн зүйлийн 12 дахь хэсгийн “Гучин найм, Гучин есдүгээр бүлэгт заасан үндэслэл, журмын” гэснийг “38.1, 38.2 дугаар зүйлд заасны” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.12 дахь заалтын “11.7 дугаар зүйлийн 1, 2, 3 дахь хэсэг” гэснийг “, 3” гэснийг, 9.1 дүгээр зүйлийн 1, 7, 9, 11, 13 дахь хэсгийн “Цагдаагийн байгууллагын” гэснийг” мөн зүйлийн 12 дахь хэсгийн “цагдаагийн байгууллагын” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.**Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 6.10 дугаар зүйлийн 3 дахь хэсэг, 6.11 дүгээр зүйлийн 1.2 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг Эрүүгийн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ГААЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Гаалийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “шийдвэрлэх, гаалийн хууль тогтоомжийг зөрчигчид хариуцлага хүлээлгэхтэй” гэснийг “шийдвэрлэхтэй” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИНЖИЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Захиргааны хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх тухай,” гэсний дараа “Зөрчил шалган шийдвэрлэх тухай,” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.1 дэх заалтын “мөрдөгч” гэсний өмнө “эрх бүхий албан тушаалтны шийдвэр,” гэж тус тус нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Шүүхийн шинжилгээний тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “төрийн эрх бүхий байгууллагын” гэснийг “эрх бүхий албан тушаалтны” гэж, 6 дугаар зүйлийн 6.1.4 дэх заалтын “төрийн эрх бүхий байгууллагыг” гэснийг “эрх бүхий албан тушаалтныг” гэж, 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “төрийн эрх бүхий байгууллага” гэснийг “эрх бүхий албан тушаалтан” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.** Энэ хуулийг Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

#### **1/6 дугаар зүйлийн 6.4.6 дахь заалт:**

“6.4.6. гадаадын иргэнийг саатуулах тухай шүүхийн шийдвэр;”

#### **2/44 дүгээр зүйлийн 44.2.15 дахь заалт:**

“44.2.15. энэ хуульд заасны дагуу төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх;”

#### **3/144 дүгээр зүйлийн 144.6 дахь хэсэг:**

“144.6. Гадаадын иргэнийг саатуулах тухай шүүхийн шийдвэрийг Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасны дагуу гүйцэтгэнэ.”

#### **4/154 дүгээр зүйлийн 154.6, 154.7 дахь хэсэг:**

“154.6. Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 154.1-д заасан үндэслэл арилсан тохиолдолд эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээх саналаа ахлах шийдвэр гүйцэтгэгчээр хянуулан 3 хоногийн дотор хувийн хэргийн хамт прокурорт хүргүүлнэ.

154.7. Прокурор энэ хуулийн 154.6-д заасан шийдвэр гүйцэтгэгчийн саналыг хүлээн авмагц сэргээх үндэслэлийг хянаж, 3 хоногийн дотор эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг сэргээх эсэхийг шийдвэрлэж тогтоол гаргана.”

#### **5/186 дугаар зүйлийн 186.3 дахь хэсэг:**

“186.3. Хорих анги нь хоригдлыг хорих ялаас хугацаанаас өмнө суллаж, хяналт тогтоох тухай шүүгчийн захирамжийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор хоригдлын зан байдал, засрал хүмүүжлийн талаарх тодорхойлолтыг шүүгчийн захирамжийн хамт түүний оршин суух газрын шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтэст хүргүүлнэ.”

**6/187 дугаар зүйлийн 187.3 дахь хэсэг:**

“187.3.Тогтоолын биелэлтийг хойшлуулсан өсвөр насны хүн, түүний эцэг, эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч, түүнчлэн өсвөр насны хүнийг хараа хяналтдаа байлгаж, хүмүүжүүлэхээр зөвшөөрсөн иргэн нь шийдвэр гүйцэтгэгчийн дуудсан цагт хүрэлцэн ирэх, шүүхээс даалгасан үүрэг, шийдвэр гүйцэтгэгчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх үүрэгтэй.”

**7/193 дугаар зүйлийн 193.1.7 дахь заалт:**

“193.1.7.шүүхийн шийдвэрт заасан албадлагын арга хэмжээг бүрэн биелүүлсэн.”

**8/264 дүгээр зүйлийн 264.1.10 дахь заалт:**

“264.1.10.согтуурах, мансуурах донтой хүн болон эмнэлгийн чанартай албадлагын арга хэмжээ авагдсан этгээдийг албадан эмчлэх эмнэлэгт хүргэх ажиллагааг гүйцэтгэх.”

**9/271 дүгээр зүйлийн 271.3.5 дахь заалт:**

“271.3.5.шийдвэр гүйцэтгэгчийн саналыг үндэслэн төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн удирдах албан тушаалтны гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх, сэргээх.”

**2 дугаар зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3 дахь хэсгийн “29.1.3,” гэсний дараа “29.1.4,” гэж, 147 дугаар зүйлийн 147.1 дэх хэсгийн “болон” гэсний дараа “хувцас,” гэж, 214 дүгээр зүйлийн 214.7 дахь хэсгийн “цагдан хорих байр,” гэсний дараа “сургалт-хүмүүжлийн тусгай байгууллага,” гэж, 257 дугаар зүйлийн 257.7 дахь хэсгийн “хэлтэс нь” гэсний дараа “хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн ялтан, албадлагын арга хэмжээ авагдсан этгээд,” гэж, 287 дугаар зүйлийн 287.8.3 дахь заалтын “хоригдолтой” гэсний өмнө “ялтан,” гэж, 293 дугаар зүйлийн 293.1.1 дэх заалтын “гав” гэсний өмнө “гар, хөл, хурууны” гэж тус тус нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

**1/18 дугаар зүйлийн 18.7 дахь хэсэг:**

“18.7.Гүйцэтгэх баримт бичгийг төлбөр авагчид буцаасан тохиолдолд энэ хуулийн 18.1, 18.5-д заасан хугацааг гүйцэтгэх баримт бичгийг буцааснаас эхлэн шинээр тоолно.”

**2/31 дүгээр зүйлийн 31.1.2 дахь заалт:**

“31.1.2.төлбөр авагч шүүхийн шийдвэрт заасан, эсхүл төлбөрт гаргуулсан боловч худалдан борлогдоогүй эд хөрөнгийг төлбөрт тооцон авахаас татгалзсан;”

**3/59 дүгээр зүйл:****“59 дүгээр зүйл.Гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх**

59.1.Тавин сая төгрөгөөс дээш хөрөнгийн шаардлага бүхий гүйцэтгэх баримт бичгийн шаардлагыг тогтоосон хугацаанд биелүүлээгүй, эсхүл тэжээн тэтгэх үүргээ 3 сараас дээш хугацаагаар биелүүлээгүй төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг дараах үндэслэлээр түдгэлзүүлж болно:

59.1.1.эрэн сурвалжлагдаж байгаа, эсхүл төлбөр төлөхөөс санаатай зайлсхийсэн;

59.1.2.хөрөнгөө нуун дарагдуулсан;

59.1.3.төлбөр төлөхөөс зайлсхийх зорилгоор гадаад улсад оргон зайлж болзошгүй.

59.2.Энэ хуулийн 59.1-д заасан шийдвэр гарсан бол төлбөр төлөгч-иргэн, төлбөр төлөгч-хуулийн этгээдийн удирдах албан тушаалтан, эсхүл төлөөлөгчид түүний гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай мэдэгдэнэ.

59.3.Шийдвэр гүйцэтгэгч төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түдгэлзүүлэх тухай саналыг ахлах шийдвэр гүйцэтгэгчид, ахлах шийдвэр гүйцэтгэгч үндэслэлтэй гэж үзвэл ажлын 3 өдрийн дотор ерөнхий шийдвэр гүйцэтгэгчид хүргүүлж шийдвэрлүүлнэ.

59.4.Төлбөр төлөгч албан ажлын, эсхүл эрүүл мэндийн шалтгаанаар түр хугацаагаар гадаадад зорчих зайлшгүй шаардлага гарсан тохиолдолд энэ хуулийн 44 дүгээр зүйлд заасан иргэний шийдвэр гүйцэтгэх ажиллагааг баталгаажуулах шаардлагатай арга хэмжээ авсны үндсэн дээр төлбөр төлөгчийн гадаадад зорчих эрхийг түр сэргээнэ.”

**4/73 дугаар зүйлийн 73.5 дахь хэсэг:**

“73.5.Төлбөр авагчийн барьцаанд байгаа, эсхүл дундын өмчлөлийн худалдан борлогдоогүй төлбөр төлөгчид ногдох хөрөнгийг энэ хуулийн 55.3-т заасны дагуу тогтоосон үнэлгээгээр тооцож, үнийн дүнгийн зөрүүг төлснөөр төлбөр авагчид шилжүүлнэ.”

**5/155 дугаар зүйлийн 155.2 дахь хэсэг:**

“155.2.Шийдвэр гүйцэтгэгч энэ хуулийн 158.2-т заасны дагуу прокуророор хянуулсан эрүүгийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсон тухай шийдвэрийг ажлын 3 өдрийн дотор цагдаагийн байгууллагад хүргүүлнэ.”

**4 дүгээр зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.6 дахь заалтын дугаарыг “6.4.7” гэж, 19 дүгээр зүйлийн 19.2 дахь хэсгийн “185” гэснийг “188” гэж, 44 дүгээр зүйлийн 44.2.15 дахь заалтын дугаарыг “44.2.16” гэж, 44.2.16 дахь заалтын дугаарыг “44.2.17” гэж, 44.2.17 дахь заалтын дугаарыг “44.2.18” гэж, мөн зүйлийн 44.4 дэх хэсгийн “гомдол гаргана.” гэснийг “, ерөнхий шийдвэр гүйцэтгэгчийн шийдвэрийг хүлээн авснаас хойш 14 хоногийн дотор шүүхэд гомдол гаргаж болно.” гэж, 50 дугаар зүйлийн 50.3 дахь хэсгийн, 53 дугаар зүйлийн 53.1, 53.3 дахь хэсгийн, 92 дугаар зүйлийн 92.2 дахь хэсгийн, 96 дугаар зүйлийн 96.4 дэх хэсгийн, 98 дугаар зүйлийн 98.7 дахь хэсгийн, 127 дугаар зүйлийн 127.4 дэх хэсгийн, 156 дугаар зүйлийн 156.3 дахь хэсгийн, 158 дугаар зүйлийн 158.2 дахь хэсгийн, 177 дугаар зүйлийн 177.3 дахь хэсгийн, 178 дугаар зүйлийн 178.1.1 дэх заалтын, 182 дугаар зүйлийн 182.2 дахь хэсгийн, 187 дугаар зүйлийн 187.2.1, 187.2.2, 187.2.3, 187.2.4 дэх заалтын, 203 дугаар зүйлийн 203.2.3 дахь заалтын, 224 дүгээр зүйлийн 224.3 дахь хэсгийн, 239 дүгээр зүйлийн 239.5 дахь хэсгийн, 262 дугаар зүйлийн 262.1.3 дахь заалтын, 267 дугаар зүйлийн 267.2.8 дахь заалтын “албанд” гэснийг “газар, хэлтэст” гэж, 64 дүгээр зүйлийн 64.5 дахь хэсгийн, 177 дугаар зүйлийн 177.4 дэх хэсгийн, 186 дугаар зүйлийн 186.1 дэх хэсгийн, 187 дугаар зүйлийн 187.1.9, 187.2.5 дахь заалтын, 242 дугаар зүйлийн 242.1, 242.2 дахь хэсгийн “алба” гэснийг “газар, хэлтэс” гэж, 164 дүгээр зүйлийн 164.5 дахь хэсгийн, 224 дүгээр зүйлийн 224.2 дахь хэсгийн, 225 дугаар зүйлийн 225.2 дахь хэсгийн, 242 дугаар зүйлийн 242.2.1 дэх заалтын, 263 дугаар зүйлийн 263.1.1 дэх заалтын, 272 дугаар зүйлийн 272.2 дахь хэсгийн “албаны” гэснийг “газар, хэлтсийн” гэж, 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсгийн “шийдвэр гүйцэтгэгчийн хөрөнгийн үнэлгээ тогтоосон шийдвэрийг” гэснийг “хөрөнгийн үнэлгээний талаарх мэдэгдэх хуудсыг” гэж, мөн зүйлийн 78.2 дахь хэсгийн “шийдвэр гүйцэтгэгчийн үнэлгээ тогтоосон шийдвэрт” гэснийг “хөрөнгийн үнэлгээний талаарх мэдэгдэх хуудсанд” гэж, 140 дүгээр зүйлийн 140.3 дахь хэсгийн “буцаасан, зөрчлийн шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн, дуусгавар болгосноос” гэснийг “буцааснаас” гэж, 153 дугаар зүйлийн 153.1 дэх хэсгийн “шүүхийн шийдвэрийг үндэслэн” гэснийг “шүүхийн шийдвэрийн хамт” гэж, 160 дугаар зүйлийн 160.3 дахь хэсгийн “зуруулна.” гэснийг “зуруулна. Сунгасан хугацаа дуусмагц торгох ялыг хорих ялаар солиулах саналаа прокурорт даруй хүргүүлнэ.” гэж,



164 дүгээр зүйлийн 164.1 дэх хэсгийн “өөрөө зөвшөөрсөн тохиолдолд ажлын өдөр ажил болон хичээлийн дараа 4 цагаас ихгүй” гэснийг “ялтан өөрөө зөвшөөрсөн тохиолдолд 8 цагаас ихгүй” гэж, 186 дугаар зүйлийн 186.2.3 дахь заалтын “этгээд” гэснийг “өсвөр насны хүн” гэж, мөн зүйлийн 186.2.4 дэх заалтын “этгээдийн” гэснийг “өсвөр насны хүн, түүний” гэж, 187 дугаар зүйлийн 187.1.3 дахь заалтын “этгээдийг” гэснийг “өсвөр насны хүнийг” гэж, мөн зүйлийн 187.1.4 дэх заалтын “этгээдийн” гэснийг “өсвөр насны хүн, түүний” гэж, 189 дүгээр зүйлийн 189.6 дахь хэсгийн “албатай” гэснийг “газар, хэлтэстэй” гэж, мөн зүйлийн 189.13 дахь хэсгийн “тусгай зөвшөөрөл бүхий магадлан итгэмжлэгдсэн” гэснийг “зөвшөөрөл бүхий” гэж, 226 дугаар зүйлийн 226.1 дэх хэсгийн “Эрүүгийн хуульд заасан тэнсэн суллагдах” гэснийг “Эрүүгийн хуулийн 6.12 дугаар зүйлд заасан” гэж, 257 дугаар зүйлийн 257.4 дэх хэсгийн “хэлтэс” гэснийг “хэлтсийг Засгийн газрын шийдвэрээр” гэж, 268 дугаар зүйлийн 268.1.1 дэх заалтын “албыг” гэснийг “газар, хэлтсийг” гэж, мөн зүйлийн 268.1.4 дэх заалтын “хорих ял эдлүүлэхийг хойшлуулсан, тэнсэн сулласан ялтан” гэснийг “тогтоолын биелэлтийг хойшлуулсан этгээдэд” гэж, 270 дугаар зүйлийн 270.3 дахь хэсгийн “мэргэжил,” гэснийг “боловсрол, мэргэжил, мэргэшил,” гэж, 272 дугаар зүйлийн 272.2.1 дэх заалтын “анги, хорих ял эдлүүлэх албаны” гэснийг “анги, байгууллагын үйл ажиллагааг мэргэжлийн удирдлагаар хангах, тушаал, шийдвэр гаргах,” гэж, 278 дугаар зүйлийн 278.1 дэх хэсгийн “, тэргүүн дэд дарга, дэд дарга нар нь цэргийн дээд цолтой байна” гэснийг “цэргийн дээд цолтой байж болно” гэж, 281 дүгээр зүйлийн 281.3 дахь хэсгийн “281.1-д” гэснийг “281.1.2, 281.1.3, 281.1.4-т” гэж, 286 дугаар зүйлийн 286.7 дахь хэсгийн “тусгай байгууллагад” гэснийг “тусгай байгууллага болон харьяа бусад байгууллагад” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 124 дүгээр зүйлийн 124.4 дэх хэсгийн “, эсхүл захиргааны шийдвэр гүйцэтгэх ажиллагааг түдгэлзүүлсэн” гэснийг, 165 дугаар зүйлийн 165.1 дэх хэсгийн “3 цагаас илүү хугацаагаар” гэснийг, 261 дүгээр зүйлийн 261.1 дэх хэсгийн “хоёр” гэснийг, 268 дугаар зүйлийн 268.1.7 дахь заалтын “хорихоос өөр төрлийн ял шийтгүүлсэн,” гэснийг, 270 дугаар зүйлийн 270.3 дахь хэсгийн “дээд боловсролтой,” гэснийг тус тус хассугай.

**6 дугаар зүйл.** Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5 дахь хэсэг, 269 дүгээр зүйлийн 269.2 дахь хэсэг, 287 дугаар зүйлийн 287.9, 287.10 дахь хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2017 оны 06 дугаар сарын 09-ний өдөр баталсан Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 3 дугаар зүйлд “Цагдаагийн байгууллага баривчлах шийтгэл оногдуулсан шүүхийн шийдвэрийг биелүүлэх чиг үүргийг энэ зүйлд заасан хугацааны дотор үе шаттайгаар шүүхийн шийдвэр биелүүлэх байгууллагад шилжүүлнэ.” гэсэн агуулгатай хоёр дахь өгүүлбэр нэмсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### БАНКНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.7 дахь заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.2.7.төлбөр төлөгчийн дансны мэдээлэл авахаар шийдвэр гүйцэтгэгчийн гаргасан хүсэлтийг шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар, хэлтсийн дарга зөвшөөрсөн;”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА

Г.ЗАНДАНШАТАР



## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **СЭЖИГТЭН, ЯЛЛАГДАГЧИЙГ БАРИВЧЛАХ, ЦАГДАН ХОРИХ ШИЙДВЭРИЙГ БИЕЛҮҮЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Сэжигтэн, яллагдагчийг баривчлах, цагдан хорих шийдвэрийг биелүүлэх тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“7.1.Хорих байр байгуулах, өөрчлөх, татан буулгах асуудлыг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний саналыг үндэслэн Засгийн газар шийдвэрлэнэ. Хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн энэ зүйлд заасан асуудлаар Улсын ерөнхий прокурортой зөвшилцсөн байна.”

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЦАГДААГИЙН АЛБАНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Цагдаагийн албаны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.3 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“73.3.Цагдаагийн байгууллагын удирдах албан тушаалтанд цэргийн дээд цол олгож болно.”

**2 дугаар зүйл.** Цагдаагийн албаны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.2 дахь хэсгийн “Энэ хуулийн 73.1.1-д заасан цолны албан тушаалын ангилал, зэрэглэлийг Монгол Улсын Ерөнхийлөгч, энэ” гэснийг “Энэ” гэж, 75 дугаар зүйлийн 75.3 дахь хэсгийн “Энэ хуулийн 75.2-т зааснаас бусад цагдаагийн” гэснийг “Цагдаагийн” гэж, 82 дугаар зүйлийн 82.1.2 дахь заалтын “санаатай гэмт хэрэг” гэснийг “гэмт хэрэг” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Цагдаагийн албаны тухай хуулийн 73 дугаар зүйлийн 73.1.1 дэх заалт, 75 дугаар зүйлийн 75.1, 75.2 дахь хэсэг, 87 дугаар зүйлийн 87.11 дэх хэсгийг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

**4 дүгээр зүйл.**Энэ хуулийг Шүүхийн шийдвэр гүйцэтгэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2020 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### **ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.**2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2.Энэ гэмт хэргийг:

- 2.1.олон тооны мал хулгайлж;
- 2.2.бүлэглэж;
- 2.3.улсын хилээр нэвтрүүлж;
- 2.4.машин механизм ашиглаж;
- 2.5.ноцтой хохирол, хор уршиг учруулж;
- 2.6.гойд ашиг шимт малыг хулгайлж үйлдсэн бол хоёр

жилээс найман жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

**2 дугаар зүйл.**Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн тайлбарын хоёр дахь хэсгийн “хорин дөрвөн бог, найман бодоос дээш” гэснийг “найман бог, хоёр бод, түүнээс дээш” гэж, “нэг бодыг гурван богоор” гэснийг “нэг бодыг дөрвөн богоор” гэж тус тус өөрчилсүгэй.

**3 дугаар зүйл.**Эрүүгийн хуулийн 17.12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн “хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл” гэснийг хассугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**





## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 01 дүгээр  
сарын 16-ны өдөр

Улаанбаатар  
хот

### ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Зөрчлийн тухай хуулийн 13.5 дугаар зүйлийн 1.1 дэх заалтын “тээвэрлэсэн” гэсний дараа “, борлуулсан” гэж нэмсүгэй.

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг 2020 оны 01 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр  
сарын 10-ны өдөр

Дугаар 03

Улаанбаатар  
хот

### Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Засгийн газраас 2019 оны 09 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд Зөрчлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн хамт өргөн мэдүүлсэн Эрчим хүч хэмнэлтийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх уг асуудлаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэр гаргах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр  
сарын 30-ны өдөр

Дугаар 12

Улаанбаатар  
хот

### Тогтоолын хавсралтад нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07

дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсэгт “21.Үндэсний геологийн алба” гэж нэмсүгэй.

2.“Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвчийг шинэчлэн батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 2016 оны 07 дугаар сарын 21-ний өдрийн 12 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн захиргааны байгууллагын тогтолцоо, бүтцийн ерөнхий бүдүүвч”-ийн “Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг” гэсэн хэсгийн “21, 22, 23” гэсэн дугаарыг “22, 23, 24” гэж өөрчилсүгэй.

3.Үндэсний геологийн албыг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын батлагдсан төсөв, орон тооны хязгаарт багтаан байгуулж ажиллуулахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## **МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ**

2020 оны 01 дүгээр  
сарын 31-ний өдөр

Дугаар 17

Улаанбаатар  
хот

### **Монгол Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын тухай**

Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Монгол Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганаар дараах асуудлыг хэлэлцэхээр төлөвлөсүгэй:

1/Монгол Улсын нэгдсэн төсвийн 2021 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2022-2023 оны төсвийн төсөөллийн тухай хуулийн төсөл;

2/“Монгол Улсын 2019 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Монгол Улсын 2019 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Монгол Улсын Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан;

3/Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2019 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлт;

4/“Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2021 онд хөгжүүлэх үндсэн чиглэл батлах тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

5/““Алсын хараа 2050”, Монгол Улсын урт хугацааны хөгжлийн үзэл баримтлал” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

6/Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;



7/Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

8/Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн төсөл;

9/Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

10/Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

11/Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

12/Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

13/Нийслэлийн эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

14/Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

15/Улс төрийн намын тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл;

16/Улс төрийн намын санхүүжилтийн тухай хуулийн төсөл;

17/“Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийг товлож, санал авах өдрийг тогтоох тухай” Монгол Улсын Их Хурлын тогтоолын төсөл;

18/бусад.

2.Хэлэлцүүлгийн шатанд байгаа болон Монгол Улсын Ерөнхийлөгч, Монгол Улсын Их Хурлын гишүүн, Монгол Улсын Засгийн газраас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн энэ тогтоолын 1-д зааснаас бусад хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг Монгол Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцүүлэх эсэх асуудлыг тухай бүрд нь шийдвэрлэж байхаар тогтоосугай.

3.Монгол Улсын хууль тогтоомжийг 2020 он хүртэл боловсронгуй болгох үндсэн чиглэл, Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэхтэй холбогдсон хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг хууль санаачлагчаас өргөн мэдүүлбэл Монгол Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын дараалалд оруулахыг Монгол Улсын Их Хурлын дарга /Г.Занданшатар/-д зөвшөөрсүгэй.

4.Монгол Улсын Их Хурлын 2020 оны хаврын ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын бэлтгэл хангахыг Монгол Улсын Их Хурлын Байнгын хороод, Монгол Улсын Их Хурал дахь намын бүлэг, зөвлөл, Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/, Монгол Улсын Их Хурлын Тамгын газар /Л.Өлзийсайхан/-т тус тус үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр  
сарын 31-ний өдөр

Дугаар 18

Улаанбаатар  
хот

### **Санхүүгийн зохицуулах хорооны зарим гишүүнийг нөхөн томилох тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 15.2 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Түдэвийн Цэрэнбадрал, Нанжидын Хүдэрчулуун нарыг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүнээр нөхөн томилсугай.

2.Энэ тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 01 дүгээр  
сарын 31-ний өдөр

Дугаар 19

Улаанбаатар  
хот

### **Санхүүгийн зохицуулах хорооны гишүүнийг чөлөөлөх тухай**

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1.2 дахь заалт, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Отгонбатын Батбилэгийг Санхүүгийн зохицуулах хорооны орон тооны гишүүний үүрэгт ажлаас чөлөөлсүгэй.

2.Энэ тогтоолыг 2020 оны 01 дүгээр сарын 31-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН  
ИХ ХУРЛЫН ДАРГА**

**Г.ЗАНДАНШАТАР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2020 оны 02 дугаар  
сарын 12-ны өдөр

Дугаар 10

Улаанбаатар  
хот

### **Засгийн газарт чиглэл өгөх тухай /Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх тухай/**

Монгол Улсын Үндсэн Хуулийн Гучин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсгийн 3 дахь заалт болон Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12 дахь хэсэг, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн



2020 оны 2 дугаар сарын 11-ний өдрийн 07/05 дугаар зөвлөмжийг тус тус үндэслэн ЗАРЛИГ БОЛГОХ нь:

1. Дэлхийн олон улс болон манай хөрш БНХАУ-д шинэ коронавирусийн тархалт эрс нэмэгдэж байгаатай холбогдуулан 17 дугаар жарны Хотол төгс хэмээх төмөр хулгана жилийн Цагаан сарын баярыг тэмдэглэхгүй байж, болзошгүй аюулаас урьдчилан сэргийлэх зорилгоор дараах арга хэмжээ авахыг Засгийн газарт чиглэл болгосугай:

1.1. Шинэ коронавирусийн тархалтын нөхцөл байдалтай уялдуулан хүн амыг урьдчилан сэргийлэх зорилгоор Гамшгаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх хэсэгт заасан гамшгаас хамгаалах бэлэн байдлын зэрэглэлийг үе шаттайгаар сонгон хэрэгжүүлэх шийдвэр гаргах;

1.2. Олон улсын хөл хориот болон халдварт бусад өвчнөөс урьдчилан сэргийлэх, өвчин гарсан үед тархаахгүй байх, таслан зогсоох зорилгоор хорио цээрийн дэглэм тогтоох асуудлыг Засгийн газрын хуралдаанаар яаралтай хэлэлцэн журамлаж, мөрдүүлэх;

1.3. Цагаан сарын баярт зориулсан олон нийтийг хамруулсан үзэсгэлэн худалдаа, мэдээллийн хэрэгслээр явуулах реклам, сурталчилгааг даруй зогсоох, хэвлэл мэдээллийн хэрэгслээр шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх иргэдийн үүрэг, хариуцлага, уг халдварын хор хөнөөлийг ухуулан ойлгуулах ажлыг хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

1.4. Дэлхий дахинд хүнээс хүнд, мал, амьтнаас хүнд халдварлах халдварт өвчин ихээр тархах болсонтой холбогдуулан Гамшгаас хамгаалах тухай, Эрүүл мэндийн тухай болон бусад хууль тогтоомжийг боловсронгуй болгох хууль тогтоомжийн төслийг боловсруулж, Улсын Их Хурлын хаврын чуулган, шаардлагатай бол ээлжит бус чуулганаар яаралтай горимоор хэлэлцүүлэх.

2. Шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх үүргээ ухамсарлан, өөрийн болон нийтийн эрх ашгийг эрхэмлэхийг нийт ард иргэдэд уриалсугай.

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙЛӨГЧ**

**МОНГОЛ УЛСЫН  
ЕРӨНХИЙ САЙД**

**ХАЛТМААГИЙН БАТТУЛГА**

**УХНААГИЙН ХҮРЭЛСҮХ**

**Хаяг:**

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц,  
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот  
И-мэйл: turin\_medeel@parliament.mn

**Утас: 262420**

Хэвлэлийн хуудас: 5,75

**Индекс: 200003**